

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2002 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч
Ч.Ганбат

Монгол Улсын Дээд шүүхийн эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улиран өнгөрч байгаа 2002 он Монголын нийт шүүх, шүүгчид, шүүхийн байгууллагын ажилтнуудын хувьд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг багц хуулиудын шинэчилсэн төслийг боловсруулах ажлыг хэсэгт ажилллах, уг багц хуулиудыг батлагдаж хүчин төгөлдөр болсон үеэс нь эхлэн хэрэгжүүлж, шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх;

Шүүхийн тухай шинэ хууль, эрх зүйн шинэ орчинтой уялдуулж, шүүх, түүний байгууллагуудыг шинэчлэн байгуулж ажиллуулах;

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Дээд шүүх, Нийслэлийн болон зарим дүүргийн шүүхэд биечлэн очиж ажил байдалтай нь танилцаад өгсөн үүргийг биелүүлэх их ажлын жил байлаа.

Монгол Улсын Их Хурлаас шүүгч, шүүх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг Эрүү, Иргэн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай болон Шүүхийн тухай хуулийг шинэчлэн баталж, 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэллээ.

2002 он Монголын нийт шүүх, шүүгчид, шүүхийн байгууллагын ажилтнуудад амжилт бүтээл, дутагдал, бэрхшээлийн аль аль нь тулгарсан жил байлаа.

Ийм нөхцөлд манай дийлэнх шүүгч, ажилтнууд албан үүргээ зохих ёсоор амжилттай биелүүлж байгааг Төр, засаг өндрөөр үнэлж Улсын Дээд шүүхийн шүүгч А.Доржготов, Д.Тунгалаг, Нийслэлийн шүүхийн шүүгч Д.Цэвээнцэрэн, Б.Сарантуяа, Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгч М.Нямжанцан, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Дамдиндорж, Багануур дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Сүрэнжав, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Т.Уранцэцэг, Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Д.Цэрэнпил нарын 9 хүнийг “**Алтан гадас**” одонгоор;

Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Амарсайхан, Баян-Өлгий аймгийн шүүхийн Тамгын газрын дарга А.Рота, Улсын Дээд шүүхийн тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэг нарын 3 хүнийг “**Хөдөлмөрийн хүндэт медаль**”-иар шагнаж, урам хайрласан юм.

Түүнчлэн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тогтоолоор Улсын Дээд шүүхийн шүүгч С.Нямжав, Д.Данзандорж, Улсын Дээд шүүхийн дэргэдэх Судалгааны төвийн захирал П.Цэцгээ, Баян-Өлгий аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Р.Асхабыл, Нийслэлийн шүүхийн шүүгч А.Чимэдцогзол, З.Цэнгэнбаяр, Д.Дамдин-Од, Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Д.Дондов, Хэнтий аймаг дахь Сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгч Б.Дэнсмаа, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч Ү.Түмэнжаргал, Улсын Дээд шүүхийн бичиг хэргийн эрхлэгч Ж.Тэгшдэлгэр нарын 11 хүнийг “**Шүүхийн байгууллагын тэргүүний ажилтан**” цол, тэмдгээр;

Хууль зүй, Дотоод хэргийн сайдын тушаалаар Дундговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Ш.Төмөрбаатар, Нийслэлийн шүүхийн шүүгч Л.Даваасүрэн, Л.Бямбаа, Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгч Г.Адъяатогтох, Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Б.Энхтайван, Төв аймаг дахь Сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Ц.Балжинням, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч М.Цэрэнбалжир, Улсын Дээд шүүхийн номын санч Б.Туяа, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн Б.Хажидмаа нарын 9 хүн “**Хууль зүйн албаны тэргүүний ажилтан**” цол, тэмдгээр шагнагдсан билээ.

Үүний зэрэгцээ зөрчил, дутагдал багагүй гарч “нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн” Баян-Өлгий аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгч К.Зулхаш, “албан үүргээ хангалтгүй биелүүлж, ноцтой зөрчил гаргасан нь Улсын Дээд шүүхийн шалгалтаар тогтоогдсон” Архангай аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгч Л.Магсаржалам нарын **2** хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчийн албан тушаалаас **огцруулж**;

“Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй”- гэсэн дүгнэлт гарсан Дорнод аймгийн Сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Х.Цэсмаа, Төв аймаг дахь Сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч Л.Ганбат, Я.Баярсайхан нарын **3** хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчийн албан тушаалаас **чөлөөлж**;

Эрүүгийн хэрэгт сэжигтнээр татагдсан учир Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл Дорноговь аймгийн шүүхийн шүүгч О.Улааныг шүүгчийн бүрэн эрхийг нь **түдгэлзүүлж** Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан юм.

Дээрх байдлаас үзэхэд шүүн таслах ажиллагаанд алдаа, зөрчил дутагдал гарсаар байгаа, хууль болон шүүгчийн ёс зүйг тэр бүр чанд мөрдөн ажиллахгүй байгаа байдал харагдаж байна.

2002 онд нийт **22** хүн шүүгчийн албан тушаалд томилогдсоны **7** нь дэвшин томилогдож, **19** хүн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний **4** нь өөрийн хүсэлтээр, **13** шүүгч төрийн өөр ажил албан тушаалд шилжиж, **2** шүүгч өндөр насны тэтгэвэрт гарчээ.

Хууль зүй, Дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран “Ял шийтгэлийн тухай тэмдэглэл үйлдэх, хүргүүлэх, хяналт тавих журам”, Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран “Цагаатгалын нөхөх олговортой холбоотой хэргийг хянах журам”, Хууль зүй, Дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах ажлын хэсэг, “Эрүү, иргэн, захиргааны хэргийг архивт шилжүүлэх, хадгалах, ашиглах, устгах журмын талаархи хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” зэрэг хамтарсан тушаал, захирамжууд гарч хэрэгжиж байна.

Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолоор Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалын зэрэг зиндааг “ТӨ-VI” байсныг Дээд шүүхийн санал болгосноор ахиулан “ТӨ-V” ангилал зэрэглэлд оруулсны зэрэгцээ, мөн оны 74 дүгээр тогтоолоор Дээд шүүхийн шүүгчийн цалинг **22%**, 77 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн шүүхийн шүүгчийн цалинг **20%**, харин анхан шатны шүүхийн шүүгчийн цалинг **25%**-иар тус тус нэмэгдүүлэн 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгож байна.

Дээд шүүх 2002 оны ажлын төлөвлөгөөндөө **5** бүлэг **106** ажлыг төлөвлөснөөс **94** нь бүрэн биелэж, **5** ажил хойшлогдож, **7** ажил тасарсан байна. Тухайлбал: Дундговь, Өвөрхангай аймгийн шүүхийн ажлыг иж бүрнээр, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн шүүхийн ажлыг хэсэгчлэн шалган туслах ажил томилолтын зардал хүрэлцээгүй болон шүүгч нарын ажлын ачаалал хэт ихэссэнээс шалтгаалан, мөн шүүгч, ажилтнуудыг зуслангийн газартай болгох тухай асуудал манай сонгосон газар нь Нийслэлийн газрын албаны энэ оны төлөвлөгөөнд тусгагдаагүй зэргээс шалтгаалан хойшлогдсон байна.

Харин “Ашигт малтмалтай холбогдох газрын маргааны талаар” Кадастрын албатай ярилцлага зохион байгуулах, “аймаг, нийслэлийн шүүхийн ажлыг шалган туслах журам”-ыг шинэчлэн батлуулах, “Шүүх, шүүгчдийн ажлыг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулан батлуулах, “Шүүх, шүүгчийн ажлын норматив” боловсруулан батлуулах гэсэн **4** чухал ажил онцын хүндэтгэх шалтгаангүйгээр, уг ажлыг хариуцан хийх шүүгч, ажилтнуудын идэвх санаачлага дутсанаас тасалджээ.

Түүнчлэн “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийг хэвлэн гаргах ажил төсөв хөрөнгөгүйн улмаас, “Цасны баяр” тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ ажил төрлийн байдлаас, “Барьцаалан зээлдүүлэх газруудтай холбогдох зээлийн гэрээний асуудлаар” Ломбардын холбоотой хамтран ярилцлага зохион байгуулах ажил Ломбардын холбооноос шалтгаалан зохион байгуулагдаагүй тасалдсан байна.

Ийнхүү хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн 5 ажил хойшлогдож, 7 ажил тасалдсанд шүүгч, ажилтнууд дүгнэлт хийж, шинэ оны эхний саруудад хийж гүйцээвэл зохино.

Ерөнхий шүүгч 18 удаа иргэн, аж ахуйн нэгж албан байгууллагын төлөөлөгч, нийт 94 хүнтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг нь сонсож, зохих хариуг өгсөн байна.

Шинээр батлагдсан Шүүхийн тухай хуулийн дагуу “Шүүгчдийн зөвлөл”-ийн анхдугаар хуралдааныг хуралдуулж, хуралдааныхаа дэгийг баталж, Шүүгчийн ёс зүйн одоогийн дүрмийг үргэлжлэн мөрдөхөөр тогтлоо.

Түүнчлэн уг хуралдаанаар Шүүхийн Ерөнхий зөвлөл, Мэргэшлийн хороо, Сахилгын хороонд орох шүүгчдийг сонгож, улмаар хуульд заасны дагуу **Ерөнхий зөвлөл, Мэргэшлийн хороо, Сахилгын хороо** байгуулан, уг байгууллагууд хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Улсын Дээд шүүхийн “Шүүгчдийн зөвлөлгөөн”-ийг 2 удаа хуралдуулж, уг зөвлөлгөөний дэг болон “Дээд шүүхэд ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, иргэний ба эрүүгийн хэргийг хүлээн авах, хуваарилах журам”-ыг хэлэлцүүлэн баталж, мөрдөж байна.

Шүүхийн үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллийг нийтэд ил тод, шуурхай хүргэх зорилгоор Ерөнхий шүүгчийн захирамжаар **Хэвлэл мэдээллийн алба**, түүний ажиллах журмыг баталж, ажилд нь оруулсан болно. Харин шүүгч, ажилтнууд хэвлэл мэдээллийн албатайгаа нягт хамтран ажиллах хэрэгтэй.

Ахмад үеийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Улсын Дээд шүүхийн Ахмадуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” Ерөнхий шүүгчийн захирамж гарган хэрэгжүүлж байна.

Улсын Дээд шүүхийн тогтоолыг нийтэд ил тод байлгах, танилцах боломжоор хангах зорилгоор “Мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах, ашиглах журам”-ыг Ерөнхий шүүгчийн захирамжаар баталлаа. Гэвч энэхүү “Нэгдсэн сан”-гийн үйл ажиллагаа одоогоор тогтмолжиж чадаагүй байгааг шүүмжлэлтэйгээр анхааруулж байна.

Монгол Улсын Шүүхийн 75 жилийн түүхэн хөгжлийг харуулсан “Шүүхийн түүхэн замнал” номыг хэвлүүлэв.

Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 75 жилийн ойг тэмдэглэх үеэр зохиогдсон “Шүүх эрх мэдэл – Шинэ зуун” сэдэвт Олон Улсын Онол – практикийн бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, манай орны нэртэй эрдэмтэд, АНУ, ХБНГУ, Японы эрдэмтэн, профессор багш нарын хэлсэн үг, тавьсан илтгэлийг ХБНГУ-ын “Ханнс-Зайдел”-ийн сангийн дэмжлэгтэйгээр “Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” ном болгон хэвлүүлж, уг номын баярыг 2002 оны 3 дугаар сарын 07-ны өдөр Улсын Дээд шүүх дээр зохион байгуулж, номын баярт оролцсон шүүгч, хуульч, төлөөлөгчдөд уг номыг гарын авлага болгон тараасан болно.

Дээд шүүхийн эрүү, иргэний давж заалдах болон хяналтын шатны шүүн таслах ажлын мэдээ гарч, Эрүү, Иргэний хэргийн танхим, Тамгын газрын тайлан тухайн нэгж, хамт олноороо нэгэнт хэлэлцэгдэж, Ерөнхий шүүгч түүнд биечлэн оролцсон тул Дээд шүүхийн 2002 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.

Монгол Улсын Дээд шүүхийн \Нийт шүүгчдийн\ хуралдааныг 16 удаа зарлан нийт 42 өдөр хуралдуулж, бүгд 332 асуудал хэлэлцэж тогтоол гаргасны дотор эрүүгийн хэрэг 57, цагаатгалын хэрэг 64, үүнээс цагаатгагдсан этгээдийн овог нэрийг зөвтгөх 16, иргэний хэрэг 190, шүүгчийн сахилгын хэрэг 4, аймгийн шүүхийг иж бүрнээр шалган тусалсан дүнгийн тухай мэдээлэл 7, хуулийн тайлбар 7-г хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

Түүнчлэн Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчид нэр дэвшүүлэх тухай асуудал хэлэлцэн Монгол Улсаас Нэгдсэн Үндэсний байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Ж.Энхсайханы нэрийг дэвшүүлж, Нийслэлийн шүүх болон Улсын Дээд шүүхэд танхим байгуулах асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргасан байна.

Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон, Архангай, Төв аймаг, Нийслэлийн шүүх тэдгээрийн харъяа сум, сум дунд, дүүргийн шүүхийн ажлыг иж бүрнээр нь шалган тусалсан тухай асуудлыг Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэн **7** тогтоол гарган холбогдох шүүхүүдэд хүргүүлжээ.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Дээд шүүхийн \нийт шүүгчдийн\ хуралдаан хийсэн өдөр **2**-оор нэмэгдэж, гэхдээ хэлэлцсэн асуудлын тоо **171**-ээр, эрүүгийн хэрэг **62**-оор, цагаатгалын хэрэг **41**-ээр, иргэний хэрэг **60**-аар, шүүгчийн сахилгын хэрэг **3**-аар тус тус цөөрч, харин аймаг, нийслэлийн шүүхийг шалгасан ажил **1**-ээр, хуулийн тайлбар **5**-аар нэмэгджээ.

Дээд шүүхийн **Эрүүгийн хэргийн танхимын давж заалдах шатаар** хэрэг хянах ажиллагаа Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуулийн дагуу 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болсон боловч "Хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх тухай" 2002 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуульд зааснаар тус танхим нь давж заалдах шатны журмаар 37 эрүүгийн хэрэг шинээр нэмж хүлээн авч, тайлангийн хугацаанд нийтдээ 238 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэв.

Давж заалдах шатны шүүн таслах ажлын энэхүү ачааллаар нэг шүүгчид дунджаар 30 эрүүгийн хэрэг ногдсон нь 2001 оны бүтэн жилийн дүнтэй харьцуулахад зөвхөн 1 хэргээр буурсан үзүүлэлттэй байна.

Давж заалдах шатны журмаар хэлэлцэгдсэн нийт хэргийн **52,1 хувь** буюу 124 таслан шийдвэрлэх тогтоол, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хэвээр батлагдаж, **27,3 хувь** буюу 65 нь өөрчлөгдөж, **20,6 хувь** буюу 49 нь хүчингүй болсон байна. Энэ үзүүлэлтийг өмнөх оныхтой харьцуулбал хэвээр батлагдсан нь 3,8 хувиар буурч, өөрчлөлт урьд оны түвшинд, хүчингүй болох явдал **4,4 хувиар** өссөн байв.

Өөрчлөлт орсон 65 хэргийн 9,2 хувь буюу 6 хэргийн зүйлчлэлийг өөрчилсөн, 36,9 хувь буюу 24 хэрэгт ялыг хөнгөрүүлсэн, 7,7 хувь буюу 5 хэрэгт дэглэмийг бууруулж, 12,3 хувь буюу 8 хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлж ял хассан, 33,9 хувь буюу 22 хэрэгт бусад өөрчлөлт оржээ.

Таслан шийдвэрлэх тогтоол, захирамж хүчингүй болсон нийт 49 хэргийн шалтгааныг задалж үзвэл: Өөр этгээдийг эрүүгийн хариуцлагад татах 1, мөрдөн байцаалт гүйцэд биш хийгдсэн 15, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн 3, хууль буруу хэрэглэсэн 9, шинэчилсэн байцаалт гүйцэд биш хийгдсэн 3, тогтоолд хийсэн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй 10, шүүхээс ялыг хөнгөдүүлсэн 4 хэрэг тус тус эзэлж байгаагаас гадна 4 хэргийн таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгон хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны журмаар шийдвэрлэсэн хэргийн 57,6 хувь буюу 137 хэрэгт шүүгдэгч, 58,4 хувь буюу 139 хэрэгт өмгөөлөгч, 25,6 хувь буюу 61 хэрэгт хохирогч, 0,8 хувь буюу 2 хэрэгт иргэдийн төлөөлөгч давж заалдах гомдол гаргасан ба 18,0 хувь буюу 43 хэргийг улсын яллагчийн эсэргүүцлээр тус тус хянан хэлэлцжээ.

Дээд шүүхийн давж заалдах шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд хэлэлцэгдсэн нийт 238 хэрэгт бүгдэд нь прокурор оролцож, 72 хэрэг буюу 30,2 хувьд өмгөөлөгч, 23 хэрэг буюу 9,6 хувьд нь хохирогч, 8 хэрэг буюу 3,3 хувьд нь шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч оролцсон байв.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгч М.Дамирансүрэн 46, Н.Төрбат 34, Д.Пунцаг 34, С.Нямжав 34, Б.Дангаасүрэн 29, Б.Доржготов 29, Д.Мөнхтуул 26, Д.Батсайхан 6 хэрэг **илтгэж** хэлэлцүүлжээ.

Давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн 238 хэргийн 49,5 хувь буюу 118 хэргийг шүүгч Д.Батсайхан **даргалсан** ба шүүгч Н.Төрбат 36, М.Дамирансүрэн 23, С.Нямжав 17, Д.Пунцаг 15, Б.Доржготов 12, Д.Мөнхтуул 9, Б.Дангаасүрэн 8 хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалсан** байна.

Давж заалдах шатны **шүүх хуралдааны бүрэлдэхүүнд** шүүгч Б.Доржготов 42, С.Нямжав 37, Б.Дангаасүрэн 35, М.Дамирансүрэн 31, Д.Мөнхтуул 30, Д.Пунцаг 26, Н.Төрбат 24, Д.Батсайхан 3 удаа тус тус **оролцжээ**.

2002 онд Нийслэлийн шүүхээс давж заалдах журмаар хэлэлцэгдсэн 84 хэргийн 52,4 хувь буюу 44 нь хэвээр батлагдаж, 32,1 хувь буюу 27 хэрэгт өөрчлөлт орж, 15,5 хувь буюу 13 хэргийн тогтоол, захирамж хүчингүй болсон байна.

Тайлангийн жилд Сэлэнгэ аймгийн шүүхээс давж заалдах журмаар хэлэлцэгдсэн 11 хэргийн 36,4 хувь буюу 4 хэрэгт өөрчлөлт орж, 27,3 хувь буюу 3 хэргийн таслан шийдвэрлэх тогтоол хүчингүй болсон, Хөвсгөл аймгийн шүүхээс 15 хэрэг хянагдсанаас 46,6 хувь буюу 7 хэрэгт өөрчлөлт орж, 20 хувь буюу 3 хэргийн таслан шийдвэрлэх тогтоол хүчингүй болсон нь бусад аймгуудтай харьцуулахад чанарын доогуур үзүүлэлттэй байв.

Харин Өвөрхангай аймгийн шүүхийн шийдвэрлэсэн 10 хэргийн 8, Хэнтий аймгийн шүүхийн 9 хэргийн 7 нь тус тус хэвээр батлагдсан нь бусад аймгуудтай харьцуулахад чанарын өндөр үзүүлэлттэй байна.

Эрүүгийн хэргийн танхим **хяналтын журмаар** эрүүгийн 629, цагаатгалын 288, нийт 917 хэрэг хүлээн авч, түүний 93,3 хувь буюу эрүүгийн 589, цагаатгалын 267 хэргийг хянаж шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар шүүгч С.Нямжав 106, Н.Төрбат 99, Б.Доржготов 94, Д.Батсайхан 76, М.Дамирансүрэн 71, Д.Мөнхтуул 68, Д.Пунцаг 64, Б.Дангаасүрэн 51 эрүүгийн **хэрэг хүлээж авсан** ба одоо танхимын хэмжээнд 40 хэрэгт ажиллагаа хийгдэж байна.

Тус танхимын шүүгчид 2002 оны 08 сарын 30-ны өдөр хүртэл хянагдсан цагаатгалын болон эрүүгийн нийт 608 хэргийн 16,6 хувь буюу 101 хэрэгт эсэргүүцэл бичсэнээс Дээд шүүхийн хяналтын шатны хуралдаанд хэлэлцэгдсэн эсэргүүцэл 100 хувь хангагдаж, хэрэгсэхгүй болгогдсон эсэргүүцэл байхгүй байна.

Дээд шүүхийн **хяналтын шатны** шүүх хуралдаанд шүүгч Н.Төрбат 28, Б.Доржготов 20, М.Дамирансүрэн 16, Б.Дангаасүрэн 12, С.Нямжав 9, Д.Пунцаг 9, Д.Батсайхан 5, Д.Мөнхтуул 2 **эсэргүүцэл бичсэн** байна.

Аймаг, Нийслэлийн шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанд шүүгч Д.Батсайхан 6, Н.Төрбат 5, Д.Мөнхтуул 5, Д.Пунцаг 4, М.Дамирансүрэн 2, шүүгч С.Нямжав, Б.Доржготов нар тус бүр **1 эсэргүүцэл** бичжээ.

Дээд шүүхийн **хяналтын шатны** шүүх хуралдаанд шүүгч Н.Төрбат 26, Б.Доржготов 21, М.Дамирансүрэн 20, Б.Дангаасүрэн 15, С.Нямжав 11, Д.Пунцаг 11, Д.Мөнхтуул 7, Д.Батсайхан 3 хэрэг **илтгэсэн** байна.

Дээд шүүхийн **хяналтын шатны** шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн 114 хэргийн 89 нь шүүгчийн, 2 нь Ерөнхий шүүгчийн, 17 нь Улсын Ерөнхий прокурорын эсэргүүцэл, дүгнэлтийн дагуу, 6 нь цаазаар авах ялтай учир "Шүүхийн тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн дагуу тус тус хэлэлцэгдлээ.

Дээд шүүхийн **хяналтын шатны** шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн эрүүгийн 50 хэргийн 14 хувь буюу 7 тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 50 хувь буюу 25 нь өөрчлөгдсөн ба 36 хувь буюу 18 хэргийн таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгосноос 10 хэргийг прокурорт, 7 хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж, 1 хэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйгээс хэрэгсэхгүй болгогдсон байна.

Дээд шүүхийн хуралдаанаар хянагдсан эрүүгийн хэргээс Нийслэлийн 4, Орхон 3, Дорноговь 3, Завхан 2, Булган 2, Архангай, Баянхонгор, Дорнод, Хэнтий аймгуудын тус бүр 1 таслан шийдвэрлэх тогтоол, магадлал хүчингүй болж, Нийслэлийн 10, Төв 2, Хэнтий 2, Увс 2, Дорноговь 2, Архангай 2, Булган, Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн шүүхийн тус бүр 1 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан байв.

Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн 114 хэргийн 56,1 хувь буюу 64 нь цагаатгалын хэрэг байснаас 25 хувь буюу 16 нь овог, нэр өөрчлөх, 75 хувь буюу 48 нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах тухай хэрэг байлаа.

Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Дээд шүүхийн хяналтын шатны үйл ажиллагаа өөрчлөгдөж, **Нийт шүүгчдийн** болон **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын хуралдааны хэлбэрээр явагдах боллоо.

Үүний дагуу Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар 7 хэрэг хэлцэгдсэний 3 нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, 4 хэрэг нь цаазаар авах ялтай учир "Шүүхийн тухай" хуулийн дагуу хянагдсан ба шүүгч М.Дамирансүрэн 3, Б.Доржготов 2, шүүгч Н.Төрбат, Д.Мөнхтуул нар тус бүр 1 хэрэг илтгэсэн байна.

Дээд шүүхийн **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаан нийт 12 өдөр хуралдаж, өдөрт 5-16 хэрэг хэлэлцэж, бүгд 117 хэрэг хянан шийдвэрлэсний 76,9 хувь буюу 90 нь эрүүгийн, бусад нь цагаатгалын хэрэг байв.

Дээд шүүхийн **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хяналтын** шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 68,9 хувь буюу 62 нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор, 17,8 хувь буюу 16 нь шүүгчийн урьд бичигдсэн болон прокурорын эсэргүүцлээр, 13,3 хувь буюу 12 нь прокурорын дүгнэлтээр хэлэлцэгджээ.

Хэлэлцэгдсэн нийт эрүүгийн хэргийн 43,3 хувь буюу 39 таслан шийдвэрлэх тогтоол, магадлал хэвээр батлагдаж, 30,0 хувь буюу 27 нь өөрчлөгдөж, 26,7 хувь буюу 24 нь хүчингүй болсон байна. Өөрчлөлт орсон 27 хэргийн 22,2 хувь буюу 6 нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, 11,1 хувь буюу 3 нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, 3,7 хувь буюу 1 хэрэгт хуулийг жинхэнэ агуулгаас нь буруу ойлгож хэрэглэсэн, 63 хувь буюу 17 хэрэгт бусад өөрчлөлт оржээ. Тогтоол, магадлалыг нь хүчингүй болгосон 24 эрүүгийн хэргийн 17 нь мөрдөн байцаалт гүйцэд биш хийгдсэн тул прокурорт, 3 хэргийг шүүхээр шинэчилэн хэлэлцүүлэхээр буцааж, 4 хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгажээ.

Дээд шүүхийн **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын 27 хэргийн 4 тогтоол, магадлал хэвээр батлагдаж, 25,9 хувь буюу 7 хэрэгт овог, нэрийг өөрчилж, 59,2 хувь буюу 16 хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан байна.

Дээд шүүхийн **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаан бүгд 12 өдөр хуралдаж, өдөрт 5-16 хэрэг хэлэлцэж, шүүгч Н.Төрбат 38, С.Нямжав 24, Б.Доржготов 14, М.Дамирансүрэн 12, Д.Батсайхан 11, Д.Пунцаг 10, Б.Дангаасүрэн 4, Д.Мөнхтуул 4 хэрэг **илтгэн**;

Шүүгч Д.Батсайхан 75, Н.Төрбат 30, С.Нямжав 12 хэргийн шүүх хуралдааныг **даргалж**;

Шүүгч Б.Доржготов 72, М.Дамирансүрэн 53, С.Нямжав 51, Д.Мөнхтуул 31, Н.Төрбат 30, Д.Пунцаг 24, Д.Батсайхан 18 хэргийн **шүүх хуралдаанд** тус тус **оролцжээ**.

Нийслэл болон дүүргийн шүүхүүдийн нийт 53 хэрэг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлцэгдсэнээс 22 хэргийн тогтоол, магадлал хэвээр батлагдаж, 18 нь өөрчлөлт орж, 24,5 хувь буюу 13 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосоны 8 хэргийг мөрдөн байцаалтанд, 1 хэргийг шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцааж, 4 тогтоол, магадлалыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Энэ онд шүүгч Б.Доржготов 75, С.Нямжав 68, Д.Мөнхтуул 60, Н.Төрбат 54, М.Дамирансүрэн 48, Д.Пунцаг 47, Б.Дангаасүрэн 46, Д.Батсайхан 44 эрүүгийн хэргийг тус тус **уншиж хянаад буцаасан** байна.

Тус танхим 2002 онд нийт 786 өргөдөл, гомдол хүлээн авснаас шүүгч Б.Доржготов 100, М.Дамирансүрэн 95, Н.Төрбат 95, Д.Батсайхан 25, Б.Дангаасүрэн 77, С.Нямжав 79, Д.Мөнхтуул 89, Д.Пунцаг 96 өргөдлийг хянан шийдвэрлэж, одоо **8 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

Иргэний хэргийн танхим давж заалдах шатны журмаар **2** хэрэг хүлээн авч, **1** хэргийг шийдвэрлэж, **1** хэрэг нь 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу хяналтын журмаар хэлэлцэхэд оролцоогүй шүүгч Ц.Амарсайханаас өөр байхгүй тул тогтоолоор буцаасан байна.

Тус танхимын шүүгч нар иргэд, байгууллагаас нийт 1568 өргөдөл, гомдол хүлээн авч, 1553-ийг нь буюу 99 хувийг шийдвэрлэжээ. Үүнд: шүүгч Б.Цогням 206, А.Доржготов 205, Д.Данзандорж 194, Д.Тунгалаг 179, О.Зандраа 177, П.Цэцгээ 176, Ц.Амарсайхан 158, Танхимын

тэргүүн Р.Жамъянчойжил 61 өргөдөл, гомдол, хүлээн авч шийдвэрлэж, одоо **15 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

2002 оны 9 дүгээр сарын 01-нээс өмнө ирсэн өргөдөл, гомдлын дагуу нийт 1209 иргэний хэрэг татаж хянан, 1202 хэргийн шийдвэр, магадлал үндэслэлтэй байсан учир хариу өгч, харин 181 эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлж, Аймаг, Нийслэлийн шүүхийн хяналтын шатанд 65 эсэргүүцэл бичжээ.

Дээд шүүхийн **хяналтын шатны шүүх хуралдаан** болон **нийт шүүгчдийн** хуралдаанаар нийт **190** хэрэг хэлэлцэж шийдвэрлэсний **175** нь шүүгчийн эсэргүүцлээр, **6** нь Ерөнхий шүүгчийн эсэргүүцлээр, **8** нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан хэлэлцэгдсэн байна.

Нийт **190** хэргээс **18** хэргийн шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, **76** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулан, **98** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосноос, **80** хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Шүүгч Б.Цогням иргэний 224 хэрэг татан хянаж, 137-д хариу өгч, 36 хэрэгт эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлсэнээс 26 эсэргүүцэл хангагдаж, 51 хэрэгт **Аймаг, Нийслэлийн** шүүхийн хяналтын шатны хуралдаанд эсэргүүцэл бичжээ.

Шүүгч А.Доржготов иргэний 177 хэрэг татан хянаж, 151-д хариу өгч, 22 хэрэгт эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлсэнээс, 21 эсэргүүцлийг хангажээ.

Шүүгч Ц.Амарсайхан иргэний 164 хэрэг татан хянаж, 121-д хариу өгч, 39 хэрэгт эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлсэнээс 38 эсэргүүцлийг хангаж, 3 хэрэгт Аймаг, Нийслэлийн шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанд эсэргүүцэл бичжээ.

Шүүгч Д.Тунгалаг иргэний 159 хэрэг татан хянаж, 131-д хариу өгч, 23 хэрэгт эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлсэнээс бүгд хангагдаж, 5 хэрэгт Аймаг, Нийслэлийн шүүхийн хяналтын шатны хуралдаанд эсэргүүцэл бичжээ.

Шүүгч Д.Данзандорж иргэний 157 хэрэг татан хянаж, 147-д хариу өгч, 8 хэрэгт эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлсэнээс 7 эсэргүүцлийг хангаж, 2 хэрэгт Аймаг, Нийслэлийн шүүхийн хяналтын шатны хуралдаанд эсэргүүцэл бичжээ.

Шүүгч О.Зандраа иргэний 150 хэрэг татан хянаж, 122-д хариу өгч, 25 хэрэгт эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлсэнээс, 23 эсэргүүцлийг хангаж, 3 хэрэгт Аймаг, Нийслэлийн шүүхийн хяналтын шатны хуралдаанд эсэргүүцэл бичжээ.

Шүүгч П.Цэцгээ иргэний 120 хэрэг татан хянаж, 99-д хариу өгч, 21 хэрэгт эсэргүүцэл бичсэнээс бүгд хангагджээ.

Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил иргэний 58 хэрэг татан хянаж, 54-д хариу өгч, 1 хэрэгт эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлэн, эсэргүүцлийг хангаж, 1 хэрэгт Нийслэлийн шүүхийн хяналтын шатны хуралдаанд эсэргүүцэл бичжээ.

Ийнхүү Дээд шүүхийн хуралдаанд шүүгч Б.Цогням 26 эсэргүүцэл бичиж 10-аас бусад нь, шүүгч О.Зандраа 23 эсэргүүцэл бичиж 2-оос бусад нь, шүүгч Ц.Амарсайхан 38, А.Доржготов 21, Д.Данзандорж 7 эсэргүүцэл тус тус бичиж 1-ээс бусад нь, шүүгч П.Цэцгээ 21, Д.Тунгалаг 23 эсэргүүцэл тус тус бичиж бүгд хангагдсан байна.

Шүүхийн шийдвэр, магадлал өөрчлөгдөж, хүчингүй болж байгаа шалтгаан нь шүүх зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, шүүх хуралдаанд оролцогсдын эрхийг хангаагүй, талуудын мэтгэлзэх боломж эрхийг бүрэн хангаагүй, нотлох баримтын зөрүүг шалгаагүйгээс болжээ.

2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тус танхим **хяналтын журмаар** нийт 241 хэрэг хүлээн авч, иргэний 112 хэргийг **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 56 хэргийг хяналтын шүүх хуралдаанд оруулах үндэслэлгүй учир буцаажээ. Одоо 73 хэргийн үлдэгдэлтэй байна.

Шүүгч О.Зандраа иргэний 65 хэрэг хүлээн авч, 42-г шийдвэрлэж, үүнээс 28 хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч Ц.Амарсайхан 65 хэрэг хүлээн авч, 36-г шийдвэрлэж, үүнээс 29 хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч Д.Тунгалаг 46 хэрэг хүлээн авч, 40-г шийдвэрлэж, үүнээс 32 хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил 45 хэрэг хүлээн авч, 32-г шийдвэрлэж, үүнээс 8 хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч А.Доржготов 20 хэрэг хүлээн авч, 18-г шийдвэрлэж, үүнээс 13 хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн байна.

2002 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс хойш Дээд шүүхийн **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаан 13 өдөр хуралдаж, өдөрт 8-12 хэрэг хэлэлцэн, нийт 112 хэрэг шийдвэрлэжээ.

Ингэхдээ Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил 12 өдрийн хуралдаанд оролцож, 91 хуралдааныг даргалж;

Шүүгч Ц.Амарсайхан 13 өдрийн хуралдаанд 79 хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож, 4 хуралдааныг даргалж;

Шүүгч А.Доржготов 5 өдрийн хуралдаанд 21 хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож, 3 хуралдаан даргалж;

Шүүгч О.Зандраа 13 өдрийн хуралдаанд 79 хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож, 5 хуралдаан даргалж;

Шүүгч Д.Тунгалаг 13 өдрийн хуралдаанд 80 хэрэг хянан шийдвэрлэхэд оролцсон байна.

Дээд шүүхийн **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн иргэний 112 хэргийн 1-ээс бусдыг хуулийн 30 хоногийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байгаа бөгөөд үүнээс харахад Дээд шүүхийн шүүгчдийн ажлын ачаалал эрс нэмэгдсэн, тэд бүх бололцоогоо дайчлан ажиллаж байна.

Иргэний хэргийн танхимаас 2002 онд шүүгчийн захирамж 135-ыг гаргаснаас Танхимын тэргүүн хэргийн харъяалал тогтоосон 28, шүүгчийн сахилгын хэрэг үүсгэсэн 1, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа түдгэлзүүлсэн 4, бусад шүүгч нар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа түдгэлзүүлсэн 72, улсын тэмдэгтийн хураамжийг шийдвэрлэсэн болон хэрэг хэлэлцэхээс татгалзсан 30 захирамж гаргажээ.

Улсын Дээд шүүхийн хуралдаанд тайлбар гаргуулахаар 6 төсөл хэлэлцүүлж, 5 нь гарсан ба 1 тайлбарыг гаргах шаардлагагүй гэж үзжээ.

Хоёр. Шүүхийг мэргэжил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар

Нийслэл, орон нутгийн шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах арга зам нь хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр зөв ойлгон мөрдүүлэх талаар албан ёсны тайлбар гаргах, тэдний ажлыг шалган туслах, шүүгч, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулах, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс хамтын удирдлага, зохион байгуулалтын аливаа шийдвэр гаргахад нь Дээд шүүх, Ерөнхий шүүгч, Ерөнхий Зөвлөлийн гишүүн шүүгчдээс үзүүлэх нөлөөг эрс дээшлүүлэх явдал юм.

Шинээр батлагдсан Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүгчдийн зөвлөлөөс сонгогдсон Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Мэргэшлийн хороо, Сахилгын хорооны гишүүн шүүгч нар тухайн зөвлөл, хороодоор хэлэлцэгдэж байгаа гол асуудлуудад нэгдмэл ойлголттойгоор оролцон ажиллаж байгааг тэмдэглэж байна.

Тайлангийн хугацаанд Дээд шүүхээс Монгол Улсын “Гэр бүлийн хуулийн тухай хуулийн зарим, зүйл, заалтыг тайлбарлах тухай” \Ц.Амарсайхан, Д.Тунгалаг\, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай Монгол Улсын хуулийн зүйл, хэсэг заалтыг тайлбарласан Дээд шүүхийн 1998 оны 62 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” \А.Доржготов\, Монгол Улсын Татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” \А.Доржготов, Д.Данзандорж\, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” \Р.Жамъянчойжил, А.Доржготов\, шинээр батлагдсан “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай” \Д.Батсайхан, Б.Дангаасүрэн\, “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим, зүйл заалтыг хэрэглэх журмын тухай” \М.Дамирансүрэн\, “Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тайлбарлах тухай” \Р.Жамъянчойжил, Д.Батсайхан\ зэрэг хуулийн тайлбар 7-г гаргасан нь эдгээр хуулийг нэг мөр зөв ойлгон хэрэглэх, шүүхийн практикийг нэгдмэл тогтооход ач холбогдлоо өгнө гэж үзэж байна.

Захиргааны хариуцлагын тухай, Патентын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн тайлбар төслийн хэмжээнд хийгдсэн ба шинээр батлагдсан багц хуулиудыг бүлэг тус бүрээр шүүгч нар хуваарилан авч тэдгээрийн зарим зүйл, заалтын талаар Дээд шүүхийн тайлбарыг боловсруулахаар ажиллаж байна.

Компанийн тухай хуулийн тайлбар нь уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбоотойгоор хойшлогдсон байна.

Түүнчлэн “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хориход шүүгчээс анхаарах зарим асуудал”-ын талаар **зөвлөмж** батлан, үүнтэй холбогдон гарах шүүгчийн захирамж, бүртгэлийн **загвар** гаргаж нийт шүүх, шүүгчдийн гарын авлага болгон хүргүүлээ.

Монгол Улсын “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай” 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуулийн 1, 3 дугаар заалтыг хэрэгжүүлэхийн тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харъяа хорих ангиудад хоригдож байгаа **1100** ялтны хувийн хэргийг судлан үзэж, **545** ялтаны ялыг шинэ хуульд нийцүүлэх арга хэмжээг авлаа.

2003 онд Эрүү, Иргэн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн тухай зэрэг багц хуулиудыг хэрэглэх явцад тулгарч буй асуудлуудыг Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчдийн зөвлөлгөөн семинарын үед сонсч, шаардлагатай гэж үзвэл хуулийн бусад байгууллагууд, Засгийн газар, УИХ-тай ярилцан хуульд өөрчлөлт оруулах, дээрх хуулийн зарим зүйл, заалтад Улсын Дээд шүүхээс хуулийн **тайлбар**, шаардлагатай **тойм**, **зөвлөмжийг** гаргах ажлыг хийж гүйцэтгэх болно.

Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг эмхтгэн хэвлэсэн “**Монгол Улсын хуулиуд**” ном, “Монгол Улсын хуучин ба шинэ Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудын харьцуулсан судалгаа” номыг нийт шүүгчид, шүүгчийн туслахуудад гарын авлага болгон үнэ төлбөргүй тараан хүргүүлээ.

Шинэ 2003 онд Говь-Алтай, Дундговь, Хөвсгөл аймгийн шүүхийн ажлыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй хамтран иж бүрэн, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн шүүхийн ажлыг Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран иж бүрнээр, Завхан, Архангай, Баянхонгор, Өмнөговь аймгийн шүүхийн ажлыг Шүүхийн Ерөнхий зөвлөлтэй хамтран хэсэгчлэн, Говьсүмбэр аймгийн шүүхийн ажлыг Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран хэсэгчлэн шалгахаар төлөвлөж байна.

Тайлангийн хугацаанд шүүгч, шүүгчийн туслах нийт **36** хүн, **105** хоногоор, **12** аймаг, **2** сум, Нийслэл, түүний **8** дүүрэгт томилолтоор ажиллажээ. Тухайлбал: Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв, Нийслэлийн шүүхийн ажлыг иж бүрнээр, Нийслэлийн **8** дүүрэг, Увс, Ховд, Баян-Өлгий, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн шүүхийн ажлыг хэсэгчлэн шалгаж, шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр ажилласан байна.

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах, шинэ 2003 онд шүүхийн байгууллагын шийдвэрлэх зорилтыг тодорхойлж, цаашид хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын жил бүрийн “Ээлжит цугларалт, семинар”,

“Нэгдсэн зөвлөлгөөн” ямагт чухал ач холбогдолтой байдаг. Үүнд одооноос сайтар бэлтгэж, Аймаг, нийслэлийн **22**, сум болон сум дунд, дүүргийн **38** шүүх, нийт **348** шүүгчээс тухайн орон нутагтаа Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс тогтоосон журмын дагуу ажлын үзүүлэлтээрээ шалгарч ирсэн шүүх, шүүгчдийн ажилд үнэлэлт дүгнэлт өгч, байр эзлүүлэн урамшуулбал зохино.

Түүнчлэн Ерөнхий шүүгч нарын зөвлөлгөөн, семинарыг хуулийн байгууллагуудын удирдах ажилтны Нэгдсэн зөвлөлгөөний үеэр буюу шинэ оны 2 дугаар сарын 24-26-ны хооронд хийх явдал нь ажилдаа дүгнэлт хийж, цаашид хэрхэн ажиллах зорилтоо тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Үүнд танхимууд одооноос сайтар бэлтгэх хэрэгтэй байна.

Ялангуяа тодорхой хэрэг маргааныг хяналтын журмаар хэлэлцэж шийдвэрлэн, ажлын ачааллынхаа ихийг гайхаж суухад бус харин шинэ багц хуулиудын зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд шаардлагатай албан ёсны тайлбарыг яаралтай батлан гаргаж, үүсч болох гомдол, маргааныг багасгахад голлон анхаарах нь зүйтэй юм.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

Тамгын газар нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс дотоод ажил, зохион байгуулалтын талаар 2000 оны 10 дугаар сарын 31, 2001 оны 9 дүгээр сарын 10, 2002 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, шинээр батлагдсан Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс баталсан бүтэц зохион байгуулалтад шилжих, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, шүүхийн статистик мэдээг гаргах, шүүгчийг шаардлагатай хууль тогтоомж, холбогдох мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, батлагдсан төсвийн хөрөнгийг зохих зардлаар нь үр ашигтай зарцуулж тайлагнах, ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар анхааран, тодорхой үр дүнтэй ажиллаж ирлээ.

Шинээр батлагдсан Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Улсын Дээд шүүхийн **Тамгын газрын үйл ажиллагааны журам, зохион байгуулалтын бүтэц** шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг 11 дүгээр сард дахин шинэчилж бүх ажилтнуудад гардуулан өгч, түүнд тавигдсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллаж байна.

Тамгын газрын үйл ажиллагааны журам, зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан ажилтнуудын ажлын давхардлыг арилгах, ачааллыг тэнцвэржүүлэх, нягтруулах зорилгоор зарим ажил албан тушаалыг зааглах, заримыг нь нэгтгэсэн зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авчээ.

Дээд шүүхийн төрийн захиргааны албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэн, тэднээс Шүүхийн судалгааны төвийн “Шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч”, “Шүүгчийн туслах-шинжээч”-ийн албан тушаалд сонгон шалгаруулах шалгалтыг Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 47 дугаар захирамжаар байгуулагдсан комисс “Эрх зүйн мэдлэгийн сонжуур”, “Баримт бичиг боловсруулах чадвар”, “Хууль хэрэглэх ур чадвар”, “Компьютер дээр ажиллах чадвар” гэсэн дөрвөн хэлбэрээр авахад, шалгалтад 16 ажилтан орсноос өндөр оноо авсан М.Алдар, Б.Бат-Эрдэнэ, Г.Даваадорж, Ж.Эрдэнэчимэг нарыг Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, Д.Батбаатар, Г.Буяннэмэх, Н.Дуламсүрэн, С.Одгариг, Ц.Оч нарыг Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, Ц.Нарангэрэлийг Шүүхийн судалгааны төвийн Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээчийн, Х.Батбаатарыг Шүүхийн судалгааны төвийн Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээчийн албан тушаалд Ерөнхий шүүгч, Судалгааны төвийн захиралтай зөвшилцсөний үндсэн дээр Тамгын газрын даргын тушаалаар томилон ажиллуулсан байна.

Төрийн захиргааны албанд түр хугацаагаар томилогдон ажиллаж байсан зарим ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтанд оруулж, шалгалтанд тэнцсэн Хэвлэл мэдээллийн төлөөлөгч Р.Ганпүрэв, Эрүүгийн хэргийн

танхимын шүүгчийн туслах М.Алдар, урьд нь төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэн ажиллаж байсан Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-нарийн бичгийн дарга Ц.Оч, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар нарыг төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлж, дээрх албан тушаалд нь жинхлэн томиллоо.

Тамгын газрын даргын зөвлөл 8 удаа хуралдаж, уг хурлаараа Улсын Дээд шүүхийн 2001 оны жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудад цалинтай болон цалингүй чөлөө олгох, дараа сарын цалинг нь урьдчилан олгох, ахмадын зөвлөлийн гишүүдэд буцалтгүй тусламж олгох, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан, ажил тасалсан зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт 16 асуудлыг хэлэлцэн, Тамгын газрын даргын тушаалаар шийдвэрлэжээ.

Нийт шүүх, шүүгчдийн өнгөрсөн 2001 оны ажлын дүнг үзүүлэлтийн дагуу гарган байр эзлүүлж, тэднийг шагнаж урамшуулах тухай асуудлыг боловсруулан шийдвэрлүүлж, аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчдийн семинар, зөвлөлгөөнийг “Ханнс-Зайдел”-ийн сантай хамтран “Континентал” зочид буудалд 2002 оны 1 дүгээр сарын 30-наас 2 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулав.

Улсын Дээд шүүхийн тамгын хэлтсийн даргын 2001 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 35 дугаар тушаалаар байгуулсан тооллогын комиссын шийдвэр, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн **4,545,0** мянган төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг акталж данснаас хасах, Төрийн өмчийн хорооноос зөвшөөрсөн тогтоолын дагуу бусад байгууллагад шилжүүлэн өгөх, акталсан эд зүйлсийг худалдан борлуулах зэргээр шийдвэрлэжээ.

Түүнчлэн Төрийн өмчийн хорооны 2002 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах, автомашин худалдах тухай” 236, 2002 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн “Дуудлага худалдааг дахин явуулах тухай” 395, 2002 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн “Дуудлага худалдааг дахин явуулах тухай” 581 дүгээр тогтоолын дагуу Улсын Дээд шүүхийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 42-65 УББ улсын дугаартай УАЗ-31512 маркийн автомашиныг дуудлага худалдаагаар худалдан борлуулах ажлыг зохион байгуулжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 185 дугаар тушаалаар баталсан “Архивын тооллого явуулах” журмын талаар бүх аймгийн шүүхийн Тамгын хэлтэст албан бичгээр мэдэгдэж, улсын хэмжээгээр эрүүгийн болон иргэний хэргийн тооллого явуулсан дүнг нэгтгэн Хууль зүй, Дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Түүнчлэн дээрхи журмыг үндэслэн Дээд шүүхийн Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан тооллогын комисс Дээд шүүхийн архивт хадгалагдаж байгаа эрүү, иргэний бүх хэргүүдийг тоолж, одоогийн байдлаар манай архивт **284** хавтас **57194** хуудас бүхий **145** эрүүгийн, **60** хавтас **7436** хуудас бүхий **49** иргэний, бүгд **344** хавтас **64630** хуудастай **194** хэрэг хадгалагдаж байгааг тогтоожээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэмжлэг туслалцаатайгаар төрийн төв байгууллагуудын албан хэрэг хөтлөх ажлын хүрээнд хэрэглэгддэг “Ирсэн бичгийн бүртгэл, хяналтын программ”, “Явуулсан бичгийн бүртгэл, хяналтын программ”, “Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, хяналтын программ” хангамжуудыг байгууллагынхаа бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний компьютерт суурилуулж хэвийн үйл ажиллагаанд орууллаа.

Хуулийн төв байгууллагуудын дунд /Үндсэн хуулийн цэц, Улсын Дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын Ерөнхий прокурорын газар, Монголын өмгөөлөгчдийн холбоо/ жил бүр зохиогддог “Шилжин явах цомын төлөө тэмцээн”-ийг энэ жил Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион явуулахад манай баг тамирчид амжилттай оролцож, эрэгтэй баг “Сагсан бөмбөг”, “Гар бөмбөг”, “Боулинг”-ийн тэмцээнүүдэд **тэргүүн** байр эзэлж “Алтан медаль”, Теннисний тэмцээнд **3** дугаар байр эзэлж “Хүрэл медаль” тус тус хүртэж, багуудын нийлбэр дүнгээр **2** дугаар байр эзэлжээ.

Дээд шүүхийн дэргэдэх “Залуучуудын зөвлөл”-өөс зохион байгуулж, яруу найрагч Загдын Түмэнжаргалын “Монголын тал нутаг” CD-ний баяр – бүх оддын тоглолтыг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдөр 25 залууст байгууллагын зардлаар үзүүллээ.

Тамгын газар нь 2002 онд төсвийн хөрөнгийг зохих зардлаар нь аль болох үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр гаргахгүй, өөрийн орлогыг бүрдүүлэн ажиллахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллажээ.

Улсын Дээд шүүхийн 2002 оны батлагдсан төсөв **151,9** сая төгрөг байснаас, 10,0 сая төгрөг нь сантехникийн их засварын зардалд, **141,9** сая төгрөг нь урсгал зардлын төсөв байсан. Энэ онд батлагдсан төсвийг Санхүү, эдийн засгийн яамнаас бүрэн авснаас гадна бусад орлого болох **2,155,8** мянган төгрөгийг төсөвт тусган Монгол Улсын Дээд шүүхийн төсвийн зардлыг зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж тайлагнаж ирлээ.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд **5,325,0** мянган төгрөг төлөвлөснөөс **5,685,2** мянган төгрөг зарцуулсан бөгөөд **360,2** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Гэрэл цахилгааны зардалд **2,585,1** мянган төгрөг төлөвлөснөөс **2,785,5** мянган төгрөг зарцуулж, **200,4** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Түлш, халаалтын зардалд **13,242,2** мянган төгрөг төлөвлөснөөс **11,663,8** мянган төгрөг зарцуулж, **1,578,9** мянган төгрөг хэмнэсэн;
- Тээвэр, шатахууны зардалд **6,769,8** мянган төгрөг төлөвлөснөөс **6,499,2** мянган төгрөг зарцуулж, **270,6** мянган төгрөг хэмнэсэн;
- Шуудан, холбооны зардалд **9,146,4** төгрөг төлөвлөснөөс **13,464,2** мянган төгрөг зарцуулж, **4,317,8** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Цэвэр, бохир усны зардалд **984,0** мянган төгрөг төлөвлөснөөс **716,5** мянган төгрөг зарцуулж, **267,5** мянган төгрөг хэмнэсэн;
- Дотоод албан томилолтын зардалд **1,200,0** мянган төгрөг төлөвлөснөөс **1,678,8** мянган төгрөг зарцуулж, **478,8** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Гадаад албан томилолтын зардалд **2,222,0** мянган төгрөг төлөвлөснөөс **2,222,0** мянган төгрөг зарцуулагджээ;
- Ном, хэвлэл авах зардалд **720,0** мянган төгрөг төлөвлөснөөс **377,1** мянган төгрөг зарцуулж, **342,9** мянган төгрөг хэмнэсэн;
- Нормын хувцас авах зардалд **150,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **150,0** мянган төгрөг зарцуулагдсан;
- Урсгал засварын зардалд **500,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **2,569,9** мянган төгрөг зарцуулж, **1,769,8** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Гадаад зочны зардалд **6,000,0** мянган төгрөг төлөвлөснөөс **2,121,7** мянган төгрөг зарцуулж, **3,878,3** мянган төгрөг хэмнэсэн;
- Байрны түрээсийн зардалд **303,2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **303,2** мянган төгрөг зарцуулагдсан;
- Буцалтгүй тусламж, тэтгэлэг урамшууллын зардалд **4,319,2** мянган төгрөг төлөвлөснөөс **6,520,9** мянган төгрөг зарцуулж, **2,201,7** мянган төгрөгөөр хэтэрсэн байна;
- Төлбөр хураамж болон бусад зардалд **1,173,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **3,878,4** мянган төгрөг зарцуулж, **2,705,4** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Бараа үйлчилгээний бусад зардалд **50,321,2** мянган төгрөг төлөвлөснөөс **54,115,4** мянган төгрөг зарцуулж, **3,794,2** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Нийгмийн даатгалын шимтгэлд **18,235,9** мянган төгрөг төлөвлөснөөс **18,352,4** мянган төгрөг зарцуулж, **116,5** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардалд **69,075,1** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **65,253,7** мянган төгрөг зарцуулж, **3,821,4** мянган төгрөг хэмнэгдсэн

байдалтай байна.

Ийнхүү зарим зардал “хэмнэгдсэн” мэтээр харагдаж байгаа нь “төсөв хангалттай бөгөөд зарцуулах зүйл олдоогүй”-гээс бус, харин төлөвлөгдсөн төсөв нь хүрэхгүй байсан бусад зардлыг нөхөн санхүүжүүлж, “урд хормойгоороо хойд хормойгоо нөхөхөд” хүрч байсныг энд зориуд тэмдэглэж байна. Тэгэхээр шүүгч, ажилтнууд бид байгууллагын төсвийн аль нэг зардлыг хэтрүүлэх нь өөр нэг зардлыг зориулалтаар нь хэрэглэж чадахгүйд хүрэх муу үр дагавартайг энэ байдал харуулж байна.

2002 онд шүүгч, ажилтнуудынхаа ая тухтай ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, зарим хүмүүсийг шагнаж урамшуулах, байгууллагын тохижилт, засвар, үйлчилгээ, бичиг хэргийн зардал болон бусад зардал зэрэг төсвийн нийт зардалд **144,0** сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Энэ тухай мэдээлэл Тамгын газрын тайланд маш тодорхой гарсан болно.

Түүнчлэн түрээсийн орлого болох 4,830,5 мянган төгрөгийг төсвийн зардал мөнгө хүрэлцдэггүй бусад арга хэмжээнүүдэд зарцуулжээ.

Энэ талаархи мэдээллийг Тамгын газрын тайлангаас тодорхой үзээрэй.

Улсын Дээд шүүхийн барилгын сантехникийн их засварын ажлын гүйцэтгэгчийг 8 оролцогчийн дундаас тендерээр сонгон шалгаруулж “Би-Софт” ХХК-иар 2002 оны 5 дугаар сарын 21-нээс 6 дугаар сарын 24-ний хооронд хийлгэж дуусган энэ өвөл шүүгч, ажилтнууд бид тав тухтай, дулаан нөхцөлд ажлаа явуулж байна.

Шинээр батлагдан мөрдөгдөж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүхийн тухай хуулиар Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаан 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянаж хэлэлцэх болсонтой холбогдуулан Хяналтын шатны шүүх хуралдааны танхимыг шинээр засварлан үйл ажиллагаанд нь орууллаа. Энэ танхимыг шаардлагатай техник хэрэгслэлээр гүйцээн тоноглож өгөх болно.

Түүнчлэн ХБНГУ-ын “Ханнс-Зайдел”-ийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр **Нийт шүүгчдийн хуралдааны танхимд** аудио болон санал хураалтын систем, бусад тоног төхөөрөмжийг “Ди-Си-Электроник” ХХК-аар суурилуулан ажиллагаанд оруулж, шүүгчдийн сандлыг шинэчлэн солилоо.

Дээд шүүхийн хамт олны дотроос гачигдал тохиолдсон шүүгч, ажилтан 10 хүнд **400,0** мянган төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж олгож, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нийт 19 шүүгч, ажилтныг тус бүр 1-2 удаа **5000** төгрөгөөр, бүгд **125,0** мянган төгрөгийг халамжийн сангаас гарган хамт олны төлөөлөгчид очиж эргэжээ. Одоо тусламжийн сан **113,6** мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2002 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 23 дугаар тушаалаар байгуулагдсан тооллогын комисс нь ажлын 15 хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, хуралдааны танхим, коридор, бестбюльд байгаа эд зүйлсийг хариуцсан үйлчлэгчдийн карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг үлдэгдлээр нь менежер, нягтлан бодогчийн бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр **102,280,752** төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, 4,209,635 төгрөгийн үнэ бүхий бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, **3,554,192** төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, **80,301,320** төгрөгийн үнэ бүхий **5** автомашин тоологдлоо.

Тооллогын комиссын саналыг үндэслэн эвдэрч хэмхрэн ашиглагдахгүй болсон зарим эд хөрөнгийг акталж, данснаас хасах шаардлагатай тул Төрийн өмчийн хорооноос зохих зөвшөөрөл авч шийдвэрлүүлэхээр бэлтгээд байна.

Дөрөв. Шүүхийн судалгааны төвийн ажлын талаар

Тус төв нь 2002 оны ажлын төлөвлөгөөндөө 28 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 27 ажил бүрэн биелэгдэж, “Шүүгчдийн ажлын ачааллын норматив”-ын төсөл боловсруулах ажил хийгдээгүй тасарсан байна.

Энэ ажлыг танхимууд АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөр”-ийн төсөлтэй хамтран чанартай, шуурхай хийж гүйцэтгэвэл зохино.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 73 дугаар тогтоолоор “Шүүхийн статистик мэдээний маягт”, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2002 оны 12 дугаар

сарын 18-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор “Шүүхийн Судалгааны төвийн дүрэм” шинэчлэн баталлаа.

Улсын Дээд шүүхээр хэлэлцэгдэн өөрчлөгдөж, хүчингүй болсон таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлалууд; эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд гарч байгаа алдаа зөрчлийн шалтгаан; авто ослын гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ялын байдал, эд зүйлсийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял; мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ялын байдал; байгаль орчин, түүний баялгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн сүүлийн 2 жилийн байдал; өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял; хууль бусаар ан агнах гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ялын байдал; бусдын биед санаатай хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн тэнцвэр; иргэдийн насыг тогтоож байгаа практик; гаалийн байгууллагад холбогдох иргэний хэргийг шийдвэрлэж байгаа шүүхийн практик; нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд холбогдох хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэж байгаа практик зэрэг асуудлаар **22** судалгаа хийжээ.

Авто ослын гэмт хэрэгт шийтгүүлэгчид шүүхээс оногдуулж байгаа ялын байдлыг 2001 оны сүүлийн хагас, 2002 оны эхний улирлаар Нийслэлийн 6 шүүхээс шийдвэрлэсэн хэргийн тогтоолуудаар хянаж, ял хөнгөдүүлсэн гэж үзсэн 30-аад хэргийг татаж хянаад шүүгчдэд танилцуулан 10 хэрэгт эсэргүүцэл бичүүлсэн байна.

Иргэний хуулийн 7, 393 дугаар зүйлд заасан нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд холбогдох бүгд 328 хэргийг \сүүлийн 3 жил\ Нийслэлийн 6 дүүргийн шүүх хэрхэн шийдвэрлэж байгаа практикийг судалсны үндсэн дээр энэ төрлийн хэргийг шүүхүүд шийдвэрлэхдээ ямар алдаа гаргаж байгаа, цаашид хуулийн заалтыг хэрхэн ойлгож зөв хэрэглэх талаар Иргэний танхимтай хамтарч тойм бичиж нийт шүүхүүдэд хүргүүлжээ.

“Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 1, 2, 3 дугаарыг хэвлүүлж, бүгд 40 орчим өгүүлэл материалыг нийтэлж гарган, 4 дэх дугаарыг хэвлүүлэхээр өрөлтөнд өгөөд байна.

Мөн Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулиуд шинээр батлагдсантай холбогдуулан сэтгүүлийн 2 дахь дугаарт Улсын Их Хурлын гишүүд, хуулийн ажлын хэсэгт оролцсон хүмүүсээр тухайн хуулиудын үзэл баримтлал болон цаашид хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар өгүүлэл бичүүлсэн нь ач холбогдолтой боллоо.

Тус төвийн ажилтнууд эрүү, иргэний **358** хэрэг хянаж, **88** эсэргүүцэл, **150** тогтоол, **49** магадлал, **82** захирамжийн төсөл боловсруулж, **153** албан бичиг төлөвлөж, **562** өргөдөл гомдолд хариу өгч, **10** зөвлөмж, **13** тойм, **6** танилцуулга бичиж, **200** гаруй иргэдтэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, шүүгчид танилцуулжээ.

Цаашид Судалгааны төв өөрийн гаргаж байгаа **зөвлөмж, тоймоо** эрүү, иргэний хэргийн танхимтай зөвшилцөж хамтран гаргаж байх нь практикийн чухал ач холбогдолтойг тэмдэглэж байна.

Тав. Гадаад арга хэмжээ, сургалт, семинарын талаар

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахууд болон Тамгын газрын ажилтнууд 2002 онд гадаад болон дотоодод болсон сургалт семинаруудад идэвхтэй оролцлоо.

Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Амарсайхан, Д.Данзандорж нарыг ХБНГУ-д шүүхийн байгууллагын туршлага судлах ажлаар “Германы Техник Хамтын Ажиллагааны Нийгэмлэг”-ийн төслийн зардлаар;

Шүүгч Д.Батсайхан Индонези улсын Бали хотноо “Хүн дамлах, хууль бусаар зөөвөрлөх болон үндэстэн дамнасан бусад гэмт хэргийн асуудлаархи” бүсийн Бага хуралд Дээд шүүхийн зардлаар;

Шүүгч М.Дамирансүрэн АНУ-ын Юта, Колорада муж улсын Шүүхийн зөвлөл, Шүүхийн захиргааны хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаатай танилцах ажлаар “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн зардлаар;

Улсын Дээд шүүхийн шүүгч байсан Д.Мөнхтуул “Олон улсын эрүүгийн шүүх байгуулах” сургалтад БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн зардлаар;

Улсын Дээд шүүхийн шүүгч байсан Шүүхийн сахилгын хорооны албаны дарга Б.Цогням “Тасралтгүй хөгжлийн стратеги” сэдэвт Шүүгчдийн давтан сургалтын төвийн захирлуудын ээлжит сургалт, семинарт “Соросын сан”-гийн зардлаар;

Монгол Улсын Дээд шүүх, АНУ-ын Техас муж улсын Уэслианы Их сургуулийн хамтын ажиллагааны гэрээ, тохиролцооны дагуу жил бүр зохиогддог давтан сургалтад Ерөнхий шүүгч Ч.Ганбат, шүүгч Б.Доржготов, О.Зандраа, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун нар Монгол Улсын Засгийн газрын болон Уэслианы Их сургуулийн зардлаар;

Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Ерөнхий шүүгчийн гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх Л.Идэр нар БНЭУ-ын Лакноу хотноо Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 3 дугаар Бага хуралд тус бага хурлыг зохион байгуулагчдын зардлаар тус тус оролцлоо.

Шинэ 2003 онд Дээд шүүхийн шүүгчдийг БНСУ-д сургалтад оролцуулах, шүүгч, ажилтнуудыг АНУ, Энэтхэг улсад сургалт, семинарт оролцуулах асуудал хэлэлцээрийн түвшинд боловсрогдож байна.

МУИС, Удирдлагын Академитай хамтран “Захиргааны шүүхийн асуудал”, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Чингэлтэй дүүрэгтэй хамтран “Хувийн өмчийн эрхийг хамгаалах нь” сэдэвт семинар, зөвлөлгөөн зохион байгуулахад манай шүүгчид идэвхтэй оролцсон байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран “Хүний эрхийн салбар дахь Олон улсын гэрээ конвенцийн хэрэгжилт” сэдвээр сургалт, семинарыг зохион байгуулж Нийслэл, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч 18 хүн, мөн шүүгчийн туслахуудыг оролцууллаа.

Татварын багц хуулиудыг нэг мөр зөв ойлгож, хэрэглэх асуудлаар Татварын Ерөнхий газар, Нийслэл, зарим дүүргийн татварын албатай хамтран “Татварын хууль тогтоомжийг зөв ойлгон хэрэглэх тухай” уулзалт ярилцлага зохион байгуулж, Татварын хуулийн талаархи тайлбарыг нэгтгэн, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийж баталсан салбар хуулиудыг зөв хэрэглэх, харилцан ойлголцож тухайн төрлийн хэрэг маргааныг зөв хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Шинээр батлагдсан Иргэний хуулийг хэрэглэх асуудлаар МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Отгонтэнгэр” Их Сургуультай хамтран онол-практикийн бага хурал зохион байгуулж, Иргэний хэргийн танхимын Тэргүүн Р.Жамъянчойжил, шүүгч Б.Цогням нар оролцож илтгэл тавилаа.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хүний эрхийн Үндэсний комисс, “Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөр” төсөл, “Ханнс-Зайдел”-ийн сан, “Хуульч эмэгтэйчүүдийн холбоо”-ноос зохион явуулсан “Төрийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох нь” сургалтад Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар;

“Хүний эрхийн салбар дахь олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилт” сургалтад шүүгчийн туслах Д.Батбаатар, Г.Даваадорж, Ц.Оч, Ж.Эрдэнэчимэг нар;

“Ажлын ачааллыг судлах нь” сургалтад Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа эрхэлсэн шинжээч Ц.Нарангэрэл, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар нар;

“Хууль зүйн дээд боловсрол олгох, хуульчдыг сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгох асуудал” онол-практикийн бага хуралд дотоод ажил зохион байгуулалт, хяналтын ажил эрхэлсэн референт Б.Баясгалан;

“Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн үзэл баримтлал” онол-практикийн бага хуралд Шүүхийн судалгааны төвийн захирал П.Цэцгээ нар оролцон санал бодлоо илэрхийлж, үг хэлсэн байна.

“Хуульчдын давтан сургалтын төв”-өөс зохион явуулдаг ээлжит сургалтад тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэгийг хамрууллаа.

Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудыг гадаад, дотоодын сургалтад хамруулах ажил цаашид ч үргэлжлэх болно.

“Ханнс-Зайдел”-ийн сангийн Эрх зүйн боловсрол академи, FM 104,5 радиотой хамтран зохион явуулж байгаа “Хуульчийн цаг” нэвтрүүлэгт Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах М.Алдар, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Н.Дуламсүрэн нар 20 гаруй удаа оролцон, шинээр мөрдөгдөж байгаа Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Хөдөлмөрийн тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай, Нийгмийн даатгалын багц хуулиудын зарим зүйл, заалтын талаархи хөдөлмөрчдийн асуултанд хариулт өгч, ярилцлага хийжээ.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ХБНГУ-ын Бавари муж улсын хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн сайд, доктор М.Вайс, НҮБ-ын Олон Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төвийн ахлах мэргэжилтэн, ноён Эдгардо Баскаллиа, ХБНГУ-ын Үндсэн Хуулийн шүүхийн шүүгч, “Ханнс-Зайделийн сан”-гийн Монголын асуудал эрхэлсэн хэлтсийн орлогч дарга Вилли Ланге, профессор Шоллер, мөн сангийн Монгол дахь төслийн удирдагч Ц.Сарантуяа, ОХУ-ын Буриад Улсын Дээд шүүхийн захиргааны хэлтсийн дарга В.В.Харханов, АНУ-ын муж улсуудын шүүхийн үндэсний төвийн Олон Улсын хөтөлбөрийн хэлтсийн менежер, хатагтай Кейн Кларк, “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн захирал, хатагтай Хайке Грамскоу, мөн төслийн зохицуулагч, ноён Роберт Ла Монт, сургалт хариуцсан ажилтан хатагтай М.Ф.Эдвардс, АНУ-ын Техас муж улсын Уэслиан Их Сургуулийн профессор, Азийн сургуулийн захирал, ноён Ж.Спурлок II, Олон Улсын Хүний эрхийн хуулийн группийн Азийг хариуцсан ажилтан хатагтай Маргерет Карфенгер, хатагтай Женифер Расмюшен, Дэлхийн банкны төслийн удирдагч, ноён А.Трофт, Буриад улсын Үндсэн хуулийн шүүхийн дарга, ноён К.А.Будаев, Азийн хөгжлийн банкны засаглал хариуцсан зөвлөх, ноён М.Раммиш, Германы техник туслалцааны хамтын ажиллагааны Нийгэмлэгийн төслийн удирдагч, ноён Л.Заяа, “Шүүгчийн боловсрол” төслийн хүрээнд айлчилсан АНУ-ын Массачусетс мужийн шүүгчийн Бага хурлын Ерөнхийлөгч бөгөөд Суффолк хотын Дээд шүүхийн шүүгч, ноён Патрик Ж.Кинг, шүүгч, ноён Томас И.Конноли, Майдлесикс хотын Дээд шүүхийн шүүгчид, хатагтай Элизабет М.Фаней, ноён Винди И.Гершенгорн, Бостон хотын шүүхийн шүүгч, ноён Жон Томас, Массачусетс мужийн шүүгчдийн зөвлөлийн гүйцэтгэх захирал, ноён Жозеф Б.Доноух, Малден дүүргийн шүүхийн шүүгч, ноён Пол Ж.Каванохь, Массачусетс мужийн Захиргааны төлөөлөгч, ноён Жон Квин, Массачусетс мужийн Насанд хүрээгүйчүүдийн шүүхийн шүүгч, ноён Ребекан Ж.Крамpton, тус мужийн гэр бүлийн шүүхийн шүүгч, ноён Жюдис Нейлсон Дилдей, ажилтан Ерика Мэри Уэйт, Тадеос Ж.Моркуечо нарын зэрэг гадаадын нийт **32** зочид, төлөөлөгчдийг **25** удаа хүлээн авч уулзан, Монголын шүүхийн гадаад харилцаа болон өөр бусад асуудлаар санал солилцож, ажил төрлийн ярилцлагууд хийсэн байна.

Тайлангийн хугацаанд бусдаасаа идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Эрүүгийн хэргийн танхимын шүүгч С.Нямжав Монгол Улсын “Шүүхийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр, Иргэний хэргийн танхимын шүүгч О.Зандраа, шүүгчийн туслах Д.Батбаатар, Б.Бат-Эрдэнэ, слесарь Б.Ширэндэв нар Дээд шүүхийн “Жуух бичиг”, мөнгөн шагналаар, Санхүү, хангамж хариуцсан нягтлан бодогч Б.Хишигсүрэн, бичээч Д.Оюунчимэг, жолооч Г.Батчулуун, үйлчлэгч Б.Уртнасан, Д.Оюунчимэг, Л.Мөнхравжих нар Дээд шүүхийн “Гэрчилгээ”, мөнгөн шагналаар шагнагдсанд хамт олныхоо өмнөөс дахин талархал илэрхийлж цаашдын ажил хөдөлмөрт нь амжилт хүсье.

Эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улирч буй 2002 онд бид нилээд зүйл хийж амжуулсан ч, шинэ 2003 онд хийх зүйл асар их байна.

Улсын Дээд шүүх, Шүүхийн байгууллагын өмнө 2003 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт: Нийтлэг зорилтууд

1. Монгол Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явц байдлыг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бусад байгууллагууд, АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийнхөн, ХБНГУ-ын “Ханнс-Зайделийн сан”, Германы Техник Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Монголын Эдийн

засгийн эрх зүйн шинэтгэл” төсөл зэрэг шүүхийн шинэтгэлийг дэмжигч байгууллагуудтай хамтран дүгнэж, цаашид хийх ажлыг тодорхойлон, 2003 оны 2 дугаар сарын 26-ны үеэр болох Хуулийн байгууллагуудын удирдах ажилтны Нэгдсэн зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэн нэгдмэл бодлогоо тодорхойлж хэрэгжүүлэх;

2.Энэ оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Шүүхийн тухай зэрэг багц хуулиудын хэрэгжилтийн байдалд судалгаа хийж, хэрэгжилтийг эрчимжүүлэх, шаардлагатай зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран санал боловсруулж ажиллах;

3.Дээр дурьдсан багц хуулиуд болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулж байгаа хуулиудын талаархи албан ёсны тайлбарыг Улсын Дээд шүүхээс батлан гаргах ажиллагааг эрчимжүүлэх, ялангуяа нэн шаардлагатай тайлбаруудыг 2003 оны 2 дугаар сард багтаан гаргаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагууд болон иргэд, хуулийн этгээдэд тараасан байх;

4.Шүүхийн тухай шинэ хуулийн дагуу шинээр байгуулагдсан Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн сахилгын болон Мэргэшлийн хороо, Шүүхийн Судалгааны төв, Сахилгын хорооны ажлын алба, Шүүгчдийн зөвлөл, Шүүгчдийн зөвлөлгөөн зэрэг байгууллагуудын ажиллах дүрэм, журмыг батлан гаргаж, зорилт чиг үүргийг нь зөв тогтоон, ажлын уялдаа холбоог нь сайжруулж, шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөшүүрэг болгон ашиглах;

5.Шүүгч, шүүхийн ажилтнуудыг сургах, давтан сургах, нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах ажиллагааг боловсронгуй болгох, шүүгч, хуульчдын давтан сургалтын Нэгдсэн систем тогтоох;

6.Улсын Их Хурлаар батлагдсан Захиргааны шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах ажлын хүрээнд Захиргааны шүүхэд ажиллах шүүгч, ажилтнуудыг бэлтгэж, давтан сургах, төв орон нутагт Захиргааны шүүх байгуулагдан ажиллах бэлтгэлийг хангах;

7.Шүүхийн гадаад харилцаа, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

Хоёрдугаарт: Эрүү, Иргэний хэргийн танхим Н.Төрбат, Р.Жамъянчойжил-д

дараах зорилтуудыг шийдвэрлэхийг үүрэг болгож байна.

1.Дээр дурьдсан шинэ багц хуулиуд болон түүний зүйл, заалтуудын талаархи Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбарын төслийг боловсруулах, энэ ажиллагаанд Шүүхийн Судалгааны төв, шүүгчийн туслахууд, эрдэмтдийн хүчин тусалцааг өргөн ашиглаж, Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах талаар тодорхой хуваарь, график гарган ажиллаж, нэн шаардлагатай тайлбаруудыг шинэ оны 2 дугаар сард багтаан гаргасан байх;

2.Улсын Дээд шүүхийн Эрүү, Иргэний хяналтын шатны 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаан болон **Нийт шүүгчдийн хуралдааны дэгийг** ойрын хугацаанд шинэчлэн боловсруулж батлуулах;

3.”Аймаг, нийслэлийн шүүхийн ажлыг шалган туслах журам”-ыг Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтад нийцүүлж шинэчлэн боловсруулж, **Нийт шүүгчдийн** хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

4.”Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах тухай” Дээд шүүхийн 1995 оны 159 дүгээр тогтоолыг Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтад нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулах;

5.Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулж, **Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд баримтлах Нэгдсэн бодлогыг** Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3-д нийцүүлэн боловсруулж Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах;

6.Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль болон Иргэний шүүн таслах ажиллагаанд баримтлах хууль тогтоомж шинэчлэгдсэнтэй холбогдуулж **иргэний шүүн таслах ажиллагаанд баримтлах Нэгдсэн бодлогыг** Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3-д нийцүүлэн боловсруулж Улсын Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар батлуулж мөрдүүлэх;

7."Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх, шүүгчдийн ажлыг үнэлж дүгнэх шалгуур", "Төв орон нутгийн шүүх, шүүгчдийн ажлын ачааллын норматив"-ыг тогтоох асуудлаар Шүүхийн Судалгааны төв, АНУ-ын "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр" төсөлтэй нягт хамтран ажиллах;

8.Шүүхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн шүүгчид сахилгын **хэрэг үүсгэх хүсэлтийг сахилгын хороонд гаргах**, шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд дүгнэлт гаргуулахаар **Мэргэшлийн хороонд хүсэлт тавих** ажиллагааг шийдвэртэй шуурхай хийж гүйцэтгэж байх;

Гуравдугаарт: Шүүхийн Судалгааны төв \П.Цэцгээ\-д үүрэг болгох нь:

1.Шүүхийн тухай хууль болон Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2002 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан Шүүхийн Судалгааны төвийн дүрмийн дагуу ажиллан, шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад эрх зүйн онол, практикийн асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистик практикийг нэгтгэн судалж, санал дүгнэлт гаргах чиглэлээр тодорхой ажил төлөвлөж хэрэгжүүлэх;

2."Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх, шүүгчдийн ажлыг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу 2002 оны шүүх, шүүгчийн шүүн таслах ажлыг үнэлж дүгнэн байр эзлүүлж, дүнг Улсын Дээд шүүхэд танилцуулах;

3."Нийслэл, орон нутгийн шүүх, шүүгчдийн ажлын ачааллын норматив"-ыг онол-практикийн үндэслэлтэйгээр шинэчлэн боловсруулж Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн хуралдаанд оруулан шийдвэрлүүлэх;

4.Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхийн статистик мэдээний маяг"-ын дагуу 2002 оны жилийн эцсийн шүүн таслах ажиллагааны мэдээг нэгтгэн гаргаж танилцуулах;

5."Шүүх, шүүгчийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг сайжруулах тухай" Улсын Дээд шүүхийн 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 159 дүгээр тогтоолыг Шүүхийн тухай шинэ хуульд нийцүүлэн танхимуудтай хамтран шинэчлэн боловсруулж, Улсын Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

6.Өөрийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан Шүүгчдийн давтан сургалтын төвийн \хуучнаар\ материал, техник, сургалтын баазыг ашиглан шаардлагатай сургалтуудыг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах;

Дөрөвдүгээрт: Тамгын газар \Д.Эрдэнэчулуун\-т үүрэг болгох нь:

1.Дээд шүүхийн 2002 оны ажлыг дүгнэн, нийт шүүгч, ажилтнуудын зөвлөлгөөнөөс өгсөн үүрэг, уг зөвлөлгөөний тэмдэглэлд дурьдсан асуудал, Ерөнхий шүүгчээс өгсөн удаа дараагийн үүрэг, байгууллагын төлөвлөгөөний биелэлтийг гүйцэд ханган ажиллах;

2.Тамгын газрыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс шинээр баталсан орон тоо, зохион байгуулалтын дагуу ажиллуулж, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хариуцан хийх ажлын чиг үүргийг улам тодорхой болгож, гүйцэтгэлийг тухай бүр нь тооцож байх;

3.Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** болон **хяналтын шатны 5 шүүгч бүхий** шүүх хуралдааны танхимыг шаардлагын түвшинд гүйцээн тохижуулж ажиллуулах;

4.Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс 2000 оны 10 дугаар сарын 31, 2001 оны 9 дүгээр сарын 10, 2002 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 1\3902 дугаар албан бичгээр тус тус өгсөн үүргүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна;

Дээд шүүхийн нийт шүүгчид, Тамгын газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ажлын алба 2003 оны 2 дугаар сарын 26-ны үеэр болох “Хуулийн байгууллагын удирдах ажилтны зөвлөлгөөн”-д сайтар бэлтгэж, Монголд өрнөж буй эрх зүйн шинэтгэлийг **шүүхийн шинэтгэл, өөрсдийн үйл ажиллагааны шинэчлэл** болгон ажиллах шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2002 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс дотоод ажил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар 2000 оны 10 дугаар сарын 31, 2001 оны 9 дүгээр сарын 10, 2002 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, шинээр батлагдсан Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс баталсан бүтэц зохион байгуулалтад шилжих, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, шүүхийн статистик мэдээг гаргах, шүүгчийг шаардлагатай хууль тогтоомж, холбогдох мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, батлагдсан төсвийн хөрөнгийг зохих зардлаар нь үр ашигтай зарцуулах, тайлагнах, ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг тухай бүр нь хэрэгжүүлэх явдал нь Улсын Дээд шүүхийн Тамгын газрын 2002 оны ажлын үндсэн зорилт байлаа.

Нэг.Удирдлага, зохион байгуулалт, дотоод ажлын талаар

Улсын Дээд шүүхийн нэгдсэн төлөвлөгөөнд хийж гүйцэтгэхээр **28** ажлыг төлөвлөснөөс, **25** ажил нь бүрэн биелэгдэж, хөрөнгө мөнгөний бололцоогүйгээс “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийг хэвлэн гаргах, ажил төрлийн боломжгүйгээс шалтгаалан “Цасны баяр” зохион байгуулах, Нийслэлийн газрын албаны төлөвлөгөөнд манай байгууллагын сонгосон газар тусгагдаагүйгээс “шүүгч, ажилтнуудын зуслангийн газартай болох” ажлууд биелэгдээгүй байна.

Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг 4 дүгээр сард шинэчлэн баталж бүх ажилтнуудаар мөрдүүлж эхэлсэн ба шинээр батлагдсан Шүүхийн тухай хуулийн дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Улсын Дээд шүүхийн **Тамгын газрын үйл ажиллагааны журам, зохион байгуулалтын бүтэц** шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг 11 дүгээр сард дахин шинэчилж бүх ажилтнуудад гардуулан өгч, түүнд тавигдсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллаж байна.

Тамгын газрын үйл ажиллагааны журам, зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан ажилтнуудын ажлын давхардлыг арилгах, ачааллыг тэнцвэржүүлэх, нягтруулах зорилгоор зарим ажил албан тушаалыг нэгтгэн, Ерөнхий шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр зарим ахмад ажилтныг өндөр насны тэтгэвэрт гаргалаа.

Улсын Дээд шүүхийн төрийн **захиргааны албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэн**, тэднээс Шүүхийн судалгааны төвийн “Шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч”, “Шүүгчийн туслах-шинжээч”-ийн албан тушаалд сонгон шалгаруулах шалгалтыг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 47 дугаар захирамжаар байгуулагдсан комисс “Эрх зүйн мэдлэгийн сонжуур”, “Баримт бичиг боловсруулах чадвар”, “Хууль хэрэглэх ур чадвар”, “Компьютер дээр ажиллах чадвар” гэсэн дөрвөн хэлбэрээр авахад, шалгалтад **16** ажилтан орсноос, өндөр оноо авсан М.Алдар, Б.Бат-Эрдэнэ, Г.Даваадорж, Ж.Эрдэнэчимэг нарыг Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, Д.Батбаатар, Г.Буяннэмэх, Н.Дуламсүрэн, С.Одгариг, Ц.Оч нарыг Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, Ц.Нарангэрэлийг Шүүхийн судалгааны төвийн Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээчийн, Х.Батбаатарыг Шүүхийн судалгааны төвийн Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээчийн албан тушаалд Ерөнхий шүүгч, шүүгч, Судалгааны төвийн захиралтай зөвшилцсөний үндсэн дээр Тамгын газрын даргын тушаалаар томилон ажиллуулж байна.

Төрийн захиргааны албанд түр хугацаагаар томилогдон ажиллаж байсан зарим ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтанд оруулж, шалгалтанд тэнцсэн Хэвлэл мэдээллийн төлөөлөгч Р.Ганпүрэв, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах М.Алдар, урьд нь төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэн ажиллаж байсан Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-нарийн бичгийн

дарга Ц.Оч, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар нарыг төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлж, дээрх албан тушаалд жинхлэн томиллоо.

Тамгын газрын даргын зөвлөл 8 удаа хуралдаж, уг зөвлөлийн хурлаар Улсын Дээд шүүхийн 2001 оны жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудаас цалинтай, цалингүй чөлөө олгох, дараа сарын цалинг урьдчилан олгох, ахмадын зөвлөлийн гишүүдээс буцалтгүй тусламж олгох зэрэг хүсэлтүүд, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан, ажил тасалсан зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт 16 асуудлыг хэлэлцэн Тамгын газрын даргын тушаалаар шийдвэрлэж, хүсэлт гаргагчид тухай бүр нь хариуг өгсөн байна.

Шүүгч, ажилтнуудын хурлаар эрхэлсэн ажилдаа үр бүтээл гарган ажиллаж байгаа зарим ажилтнуудыг төрийн дээд, одон медаль болон бусад байгууллагын шагналаар шагнуулахаар хэлэлцэн шийдвэрлэж, холбогдох байгууллагуудад тодорхойлсноор:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 83 дугаар зарлигаар Тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэг **“Хөдөлмөрийн хүндэт”** медалиар, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2002 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Бичиг хэрэг, өргөдөл гомдлын ажил хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр **“Шүүхийн тэргүүний ажилтан”** цол тэмдгээр, Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2002 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 54 дугаар тушаалаар Номын санч Б.Туяа **“Хууль зүйн албаны Тэргүүний ажилтан”** цол тэмдгээр, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 17 дугаар захирамжаар Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Г.Буяннэмэх Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн **“Өргөмжлөл”**, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

Нийт шүүх, шүүгчдийн 2001 оны ажлын дүнг үзүүлэлтийн дагуу гарган байр эзлүүлж, тэднийг шагнаж урамшуулах тухай асуудлыг боловсруулан шийдвэрлүүлж, аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчдийн семинар, зөвлөлгөөнийг “Ханнс-Зайдел”-ийн сантай хамтран “Континентал” зочид буудалд 2002 оны 1 дүгээр сарын 30-наас 2 дугаар сарын 01-ний хооронд зохион байгууллаа.

Монгол Улсад Шүүх байгуулагдсаны түүхт 75 жилийн ойг өнгөрсөн онд тэмдэглэн өнгөрүүлэх үеэр зохиогдсон “Шүүх эрх мэдэл – Шинэ зуун” сэдэвт Олон Улсын Онол – практикийн бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, манай орны нэртэй эрдэмтэд болон АНУ, ХБНГУ, Япон зэрэг орны эрдэмтэн, профессор багш нар оролцон илтгэл тавьж, үг хэлсэн баримт материалыг ХБНГУ-ын “Ханнс-Зайдел”-ийн сангийн дэмжлэгтэйгээр “Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” Олон Улсын Онол – практикийн бага хурал нэртэй ном болгон хэвлүүлж, уг номын баярыг 2002 оны 3 дугаар сарын 07-ны өдөр Улсын Дээд шүүх дээр зохион байгуулж, номын баярт оролцсон Монгол Улсын Дээд шүүх, Нийслэл, дүүргийн шүүх, Үндсэн хуулийн цэц, Хууль зүй, Дотоод хэргийн яам, Шүүхийн Ерөнхий зөвлөл, УИХ-ын Тамгын газар, Удирдлагын академи, МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль, Улсын төв номын сан, Хуульчдын нэгдсэн холбоо, Өмгөөлөгчдийн холбооны төлөөлөгчдөд болон Улсын Дээд шүүх, Нийслэл, дүүргийн шүүгчдэд гарын авлага болгон хүртээлээ.

Түүнчлэн Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг Хууль зүй, Дотоод хэргийн яам, Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “Монголын эдийн засгийн эрх зүйн шинэтгэл” төсөл, ХБНГУ-ын “Ханнс-Зайдел”-ийн сангийн Монгол дахь төлөөлөгчдийн газар, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлагаас санхүүжүүлж буй “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр эмхэтгэн хэвлүүлсэн **“Монгол Улсын хуулиуд”** номыг Улсын Дээд шүүхийн шүүгчдэд, **“Монгол Улсын хуучин ба шинэ Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг харьцуулсан судалгаа”** номыг Улсын Дээд шүүхийн шүүгчид, шүүгчийн туслахуудад гарын авлага болгон тараан өглөө.

Улсын Дээд шүүхийн тамгын хэлтсийн даргын 2001 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 35 дугаар тушаалаар байгуулсан тооллогын комиссын шийдвэр, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдсаар ирсэн эвдэрч ашиглагдахгүй болсон, илүүдэлтэй байгаа **4,545,0** мянган төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг акталж, данснаас хасах шаардлагатай байсан тул эд хөрөнгийн жагсаалт гарган, Төрийн өмчийн хорооноос зөвшөөрсөн тогтоолын дагуу 386, 486 маркийн **5 ш компьютер**, Стар,

Епсон маркийн **5 ш принтерийг** Боловсрол соёл, шинжлэх ухааны яаманд шилжүүлэн өгч, акталсан эд зүйлсийг худалдан борлуулж, **83,0** мянган төгрөг болсныг дансанд тушаажээ.

Түүнчлэн Төрийн өмчийн хорооны 2002 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах, автомашин худалдах тухай” 236, 2002 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн “Дуудлага худалдааг дахин явуулах тухай” 395, 2002 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн “Дуудлага худалдааг дахин явуулах тухай” 581 дүгээр тогтоолын дагуу Улсын Дээд шүүхийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 42-65 УББ улсын дугаартай УАЗ-31512 маркийн **автомашин**ыг дуудлага худалдаагаар худалдан борлуулах ажлыг зохион байгуулж **1756,0** мянган төгрөгийг мөн өөрийн дансанд шилжүүллээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 185 дугаар тушаалаар баталсан **“Архивын тооллого явуулах”** журмын талаар бүх аймгийн шүүхийн Тамгын хэлтэст албан тоотоор мэдэгдэж, улсын хэмжээгээр эрүүгийн болон иргэний хэргийн тооллого явуулсан дүнг нэгтгэн Хууль зүй, Дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Түүнчлэн дээрхи журмыг үндэслэн Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан тооллогын комисс нь Улсын Дээд шүүхийн архивт хадгалагдаж байгаа эрүү, иргэний бүх хэргүүдийн тооллого явуулж, одоогийн байдлаар манай архивт **284** хавтас **57194** хуудас бүхий эрүүгийн **145, 60** хавтас **7436** хуудас бүхий иргэний **49**, бүгд **344** хавтас **64630** хуудастай **194** хэрэг хадгалагдаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэмжлэг туслалцаатайгаар төрийн төв албан хэрэг хөтлөх ажлын хүрээнд хэрэглэгдэх **“Ирсэн бичгийн бүртгэл, хяналтын программ”**, **“Явуулсан бичгийн бүртгэл, хяналтын программ”**, **“Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, хяналтын программ”** хангамжуудыг байгууллагынхаа Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний компьютерт суурилуулж хэвийн үйл ажиллагаанд орууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди анх удаа Улсын Дээд шүүхийн ажил байдалтай биечлэн танилцах үед Монгол Улсын Газрын зурагт хүрээ хийн, аймаг, нийслэл, дүүрэг, сум, сум дундын шүүхийн ба Улсын Дээд шүүхийн ажлын ачаалал, үзүүлэлтийг харьцуулсан танилцуулга хийлээ.

Бичиг хэрэг, өргөдөл, гомдлын ажил хариуцсан мэргэжилтэн эрүүгийн **786**, иргэний **1568**, тамгын газрын **24**, нийт **2378** тооны өргөдөл гомдол, **1560** албан бичиг, **2705** хавтаст хэрэг, шуудангаар ирсэн **790** өргөдөл, хариутай бичиг **402**-ыг хүлээн авч, карт нээн, удирдлагад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хуварилан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **4502** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Эрүүгийн хэргийн танхимын нарийн бичгийн дарга давж заалдах шатны журмаар **238**, хяналтын шатны журмаар **629** эрүүгийн хэрэг хүлээн авч, компьютерт бүртгэн, шүүгчдэд хуваарилуулан өгснөөс гадна давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдааны бэлтгэлийг ханган, хуралдааны оролцогчдод хурлын зарыг биечлэн мэдэгдэж, давж заалдах шатны **238**, хяналтын шатны **117** шүүх хуралдаанд оролцон тэмдэглэл хөтөлж, **238** магадлал, **117** тогтоолыг нийлж, ёсчлуулан уг хэргийг холбогдох шүүхүүдэд, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас таслан шийдвэрлэх тогтоол, магадлалд өөрчлөлт орсон тухай **110** мэдэгдэх хуудас боловсруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Дүн шинжилгээ мэдээллийн төвд тус тус хүргүүлжээ.

Иргэний хэргийн танхимын нарийн бичгийн дарга иргэний **1211** хэргийг хүлээн иргэдийн өргөдлөөр иргэний **1041** хэргийг татах тогтоолоор хүлээн авсан\ авч, компьютерт бүртгэн, шүүгчдэд тойргийн журмаар хуваарилуулан өгснөөс гадна танхимын хяналтын шатны шүүх хуралдааны болон танхимын зөвлөлгөөний бэлтгэлийг ханган, **166** хэргийг танхимын зөвлөлгөөнөөр, **109** хэргийг хяналтын шатны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхэд болон танхимын дотоод ажил, жилийн ажлын төлөвлөгөө, шинээр батлагдсан Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр биелүүлэх хуулиудын хэрэгжилтийн бэлтгэл, зарим хуулиудын онолын болон албан ёсны тайлбарын төслийг хэлэлцэхэд оролцон тэмдэглэл хөтөлжээ.

Түүнчлэн Танхимын тэргүүний харъяалал тогтоох **28** захирамж, Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шүүгчийн **62** захирамжийг боловсруулан, нийлж, ёсчлуулан холбогдох шүүхэд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, Танхимын тэргүүнээс шинээр батлагдсан Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудийн үзэл баримтлал, түүнд шинээр тусгагдсан зүйл заалтуудын талаар бичсэн эмхтгэл, “Иргэдийн насыг тогтоож байгаа шүүхийн практикийн тухай” **зөвлөмжийг** Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн бүх шүүхүүдэд, Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв, Нийслэлийн иргэний бүртгэл мэдээллийн албанд тус тус хүргүүлжээ.

Дээд шүүхийн нийт шүүгчдийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хяналтын шатны **42** шүүх хуралдаанд оролцон, тэмдэглэл хөтөлж, хуралдаанаас гарсан **332** тогтоолыг нийлж, ёсчлуулан бүртгэлд авч, тогтоол, хуралдааны тэмдэглэлийн хувийг холбогдох шүүх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нь хүргүүлжээ. Мөн эрүү, иргэн, цагаатгалын **311** хэргийг үдэж цэгцлэн нарийн бичгийн дарга нарт хүлээлгэн өгсөн байна.

Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслахууд шүүгчээс шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд нь туслах, бэлтгэл ажлыг хангах зорилгоор хэрэг, маргааны талаар судалгаа хийж шүүгчид танилцуулах, шүүгчийн даалгавраар аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхүүдийн таслан шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал зэргийг хянаж, тэдгээрийн алдаа зөрчлийг арилгах, дахин гаргуулахгүй байх зорилгоор шүүгчтэй хамтран тойм зөвлөмж бичих зэрэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Тухайлбал: Улсын Дээд шүүхийн тогтоол **150**, магадлал **49**, эсэргүүцэл **88**, шүүгч томилж оролцуулах захирамж **19**, хэрэг хянан хэлэлцэх хугацааг сунгах тухай захирамж **9**, хэргийг шүүхийн харъяалал тогтоон шилжүүлэх захирамж **73**, өргөдлийн хариу **238**, албан тоот **74**-ын төслүүдийг боловсруулан бичиж хариуцсан шүүгчээрээ хянуулан ёсчлуулж, холбогдох шүүх, иргэд, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагуудад тухай бүр нь хүргүүлэх ажлыг зохион байгуулан гүйцэтгэсэн байна.

Шүүгчдэд хувиарлагдсан хэргүүдээс шүүгчийн даалгавраар **358** хэргийг уншин хэргийн тухай танилцуулга бичин шүүгчид танилцуулж, хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгон өргөдөл гаргагчид хариуг өгсөн байна.

Шүүгчийн туслахууд, шүүгч иргэдтэй уулзан санал хүсэлтийг нь сонсох үед байлцан, тэмдэглэл хөтлөн, түүнийг хэрэгт нь хавсаргаж, шүүгчийг эзгүйд санал хүсэлтийг нь хүлээн авч, тухай бүр нь шүүгчдээ танилцуулж ажилласан байна.

Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимын Тэргүүний “Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудын хэрэгжилтийн байдлыг дүүргийн шүүхүүдэд судалж, танилцах ажлын удирдамж”-ийн дагуу 2002 оны 12 дугаар сарын 2-ноос 5-ны хооронд Нийслэлийн төвийн бүх дүүргүүдийн шүүхүүдэд шинэ хуулиудын хэрэгжилтийн байдлын талаар судалж, дүгнэлт гаргах зорилгоор ажиллаж, гүйцэтгэсэн ажлын тайланг тухайн дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч болон Танхимын тэргүүн нарт танилцуулжээ.

Эрүүгийн хэргийн танхимын туслахууд танхимынхаа Тэргүүний даалгавраар шинээр батлагдан мөрдөгдөж байгаа Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудыг хуучин хуулиудтай харьцуулсан судалгаа хийж, шүүгчдэд гарын авлага бэлтгэхэд нь тусалсан байна.

Ерөнхий шүүгчийн туслах Ерөнхий шүүгчийн захирамж **118**, эсэргүүцэл **8**, дүгнэлт **4**, Танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **275**, шүүгчийн эсэргүүцэл **364**, тамгын хэлтэс, газрын даргын тушаал **84**, **4502** албан бичигт дугаар өгч, ёсчлон, Ерөнхий шүүгчийн өдөр тутмын ажилд биечлэн тусалж ажиллажээ.

Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч 203 хууль, Улсын Их Хурлын **82**, Засгийн газрын **214** тогтоолыг хүлээн авч, бүх өөрчлөлтийг хийн, хууль тогтоолын лавлагааг давхардсан тоогоор **263** хүнд өгч, гарын авлагаар ханган, Мэдээллийн санд Иргэний хэргийн **48** тогтоол, **6** зөвлөмж оруулсан байна.

Компьютерийн операторч хяналтын шатны шүүх хуралдааны материал болон бусад зайлшгүй шаардлагатай **1096** баримт бичгийг тухай бүр нь албан хэрэгцээнд **34879** хувь

олшруулан, “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 1, 2, 3 дугааруудын эхийг бэлтгэн хэвлэлтэнд шилжүүлжээ.

Олшруулсан нийт материалын **60** хувь нь хяналтын шатны шүүх хуралдааны материал байлаа.

Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн, Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимын нарийн бичгийн дарга, Цагаатгалын ажил хариуцсан операторч, бичээч нарын компьютерт байгаа баримт бичгүүдийг 7 хоногт 1 удаа хуулан авч, нөөц хувилбараар хадгалж зарим шүүгч, ажилтнуудын компьютерт шинээр Англи-Монгол хэлний толь бичиг, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах Ч.Даваадоржийн компьютерт шинээр Виндөүс 98 программ, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний компьютерт шинэ 20 гигабитын хатуу диск, фловий уян дискний машин тус тус суулган, Виндөүс 97, 98, монгол үсгийн программ таниулж, хэвийн ажиллагаанд оруулсан байна.

Жил бүрийн 5 дугаар сарын 3-ны өдөр идэвхиждэг вирусийг байгууллагынхаа компьютерт халдаахгүй урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, бичээч нарын 2 компьютер нь вирустэн хэвийн ажиллахгүй болж, бичсэн зүйл нь устгагдан, баримтууд нь нээгдэхгүй байсныг шинээр вирусын эсрэг программ суулган, хэвийн ажиллагаанд оруулж, вирусын эсрэг шинэ программыг байнга цаг алдалгүй интернетээс өөрийн компьютерт татан авч, бусад компьютерт суулгасан байна.

Улсын Дээд шүүхийн дотоод сүлжээг нэгбүрчлэн шалгаж, 3, 4 дүгээр давхруудын сүлжээний зарим кабель, RJ-45 коннекторуудыг тус тус солин, дотоод сүлжээг хэвийн үйл ажиллагаанд оруулснаас гадна одоо ашиглагдаж байгаа компьютеруудад оношлогоо хийж, 5 компьютер, 2 принтерийг засварлан, хувиран олшруулагч машинд иж бүрэн үйлчилгээг нэг удаа хийжээ.

Цагаатгалын асуудал хариуцсан операторч **561** өргөдөл, гомдол хүлээн авсны **328** өргөдөлд хэрэг татах тухай тоотыг Үндэсний төв архив, Тагнуулын Ерөнхий газрын архив, аймгуудын шүүхүүдэд хүргүүлсний хариуд **236** хавтаст хэргийг хүлээн авч, бүртгэлд оруулан, Танхимын тэргүүнд танилцуулж, цагаатгалын ажил хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилуулан өгчээ.

232 хэргийн **208** өргөдөлд зохих хариуг өгч, цагаатгалын ажил хариуцсан мэргэжилтнүүдэд хянагдаж байгаа болон хяналтын шатны шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр шүүгчийн эсэргүүцэл бичигдсэн **24** хэрэг байна.

Аймаг, сумдын цагаатгалын салбар комиссууд болон иргэдээс цагаатгалын үнэмлэх авах хүсэлт гаргасны дагуу бүртгэлд авагдсан материалуудаас хайлт хийж зохих хариуг өгч, цагаатгалын үнэмлэх **591**-ийг бичиж, иргэд, аймгуудын цагаатгалын комисст нь хүргүүлжээ.

Номын сан хариуцсан ажилтан ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Гадаад хэргийн яам, “Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр” төслөөс бэлэг болгосон **12** нэрийн **46** ширхэг монгол ном, **34** нэрийн **35** ширхэг орос ном, **79,8** мянган төгрөгөөр худалдан авсан **5** нэрийн **10** ширхэг монгол ном, нийт **91** номыг номын сандаа шинээр бүртгэн, **6** төрлийн сонин, **4** төрлийн монгол сэтгүүл, **1** төрлийн орос сэтгүүлийг ангилан дугаараар нь байрлуулж, шинээр номын санд бүртгэгдсэн ном, сэтгүүлийн тухай “мэдээлэл”-ийг **11** удаа хийж, Эрүү, Иргэний эрх зүйн сэдвээр гарсан **238** өгүүллүүдийг “Монголын төр, эрх зүй”, “Государство и право”, “Российская юстиция” сэтгүүлүүдээс түүвэрлэн ангилж, каталогид оруулсан байна.

Түүнчлэн **133** хүнд уншигчдийн үнэмлэх олгон, уншлагын танхимд давхардсан тоогоор **340** хүнд **1209** ширхэг сэтгүүл, **591** номоор үйлчилжээ.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудад **26** нэрийн **188** ширхэг номыг олгож, албан хэрэгцээнд ашиглуулсан байна.

Бичээч нар Ерөнхий шүүгчийн захирамж, шүүгчийн захирамж, Ерөнхий шүүгчийн эсэргүүцэл, шүүгчийн эсэргүүцэл, Ерөнхий шүүгчийн дүгнэлт, Танхимын тэргүүний захирамж, Тамгын газрын даргын тушаал, Улсын Дээд шүүхийн тогтоол, Эрүүгийн болон Иргэний магадлал, танилцуулга, ажлын тайлан, шалгалтын материал, албан тоот, Шүүхийн судалгааны төвөөс гаргаж буй тойм, зөвлөмж, цагаатгалын ажилтай холбоотой материал, хуулийн тайлбар, дотоод ажил,

зохион байгуулалт, хяналтын ажил хариуцсан референтээс гаргаж байгаа материал, Сахилгын хорооны дарга, гишүүдийн захирамж болон холбогдох материалууд зэрэг **1,112,854** мөр буюу **53014** хуудас бичгийг компьютерээр бичсэн байна.

Байгууллагын бичиг хүргэгч нь **1350** албан бичиг, **3507** хавтаст хэрэг, **8** зарлан дуудах хуудсыг холбогдох иргэд, аж ахуйн нэгж байгууллага, нийслэл, дүүргийн шүүхэд хүргэн, гардуулан өгсөн байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2002 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 16 дугаар захирамжаар Монгол Улсын шүүхүүдийн үйл ажиллагааг олон түмэнд сурталчлах зорилготой **“Шүүхийн хэвлэл мэдээллийн алба”** байгуулагдан, Хэвлэл мэдээллийн төлөөлөгч “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинууд, Монголын радиогийн “Хурд” агентлаг болон “MN” телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласнаар шүүхийн үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын мэдээллийг байнга нийтэлж, нэвтрүүлж хэвшээд байна.

Тухайлбал: Давхардсан тоогоор сонинд **100** гаруй, телевизээр **40** гаруй мэдээ нийтлэн, нэвтрүүлснээс гадна шүүхээс явуулж буй үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинуудад нийтлэл, ярилцлага **32**-ыг бичиж хэвлүүлэн, Монголын радиогийн “Соёмбо” нэвтрүүлгээр энэ оны **1** дүгээр сараас **9** дүгээр сар хүртэлх хугацаанд Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудаар долоо хоног тутам 5-10 минут шүүгч нартай ярилцлага хийх ажлыг зохион байгууллаа.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр шүүхийн дутагдал, доголдолтой тал болон шүүн таслах үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг шүүмжлэн бичсэн нийт 160 гаруй нийтлэл нийтлэгдсэнийг бүртгэн Ерөнхий шүүгчид танилцуулж, эдгээрээс шүүхийн үйл ажиллагаатай холбоотой гүтгэлгийг няцаах зорилгоор 14 залруулга бичсэнээс 6 нь ямар нэг хэлбэрээр сонинд хэвлэгджээ. Мөн телевизээр Улсын Дээд шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бодит байдлыг илтэд гуйвуулсан нэвтрүүлэг явуулсан тул сониноор дамжуулан хариу мэдэгдэл гаргасан байна.

Хуулийн төв байгууллагуудын дунд Үндсэн хуулийн цэц, Улсын Дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын Ерөнхий прокурорын газар, Монголын өмгөөлөгчдийн холбоо/ жил бүр зохиогддог “Шилжин явсан цомын төлөө тэмцээн”-ийг энэ жил Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион явуулахад манай баг тамирчид амжилттай оролцож, эрэгтэй баг “Сагсан бөмбөг”, “Гар бөмбөг”, “Боулинг”-ийн тэмцээнүүдэд **тэргүүн байр** эзэлж “Алтан медаль”, Теннисний тэмцээнд **3** дугаар байр эзэлж “Хүрэл медаль” тус тус хүртэж, багуудын нийлбэр дүнгээр **2** дугаар байр эзэллээ.

Дээрх спортын тэмцээнд Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах М.Алдар, Г.Даваадорж, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Д.Батбаатар, Ц.Оч, Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт, жолооч Б.Жумдаандорж, үйлчлэгч Б.Уртнасан нар бусдаасаа илүү идэвх, зүтгэл гарган оролцсоныг тэмдэглэх нь зүйтэй байна.

Улсын Дээд шүүхийн дэргэдэх **“Залуучуудын зөвлөл”**-өөс зохион байгуулж, байгаа ажил, үйл ажиллагааг нь дэмжих, тэдэнд цаашид үр бүтээлтэй ажиллах урам зориг хайрлах зорилгоор Ерөнхий шүүгчийн санаачлагаар нэг бүр нь 6000 төгрөгийн үнэтэй яруу найрагч Загдын Түмэнжаргалын “Монголын тал нутаг” CD-ний баяр – бүх оддын тоглолтыг 2002 оны 5 дугаар сарын 23-ны өдөр “Залуучуудын зөвлөл”-ийн гишүүн 25 залуучуудаа байгууллагын зардлаар үзүүллээ.

2001 оны Тамгын хэлтсийн тайлангийн хурал дээр ажилтнуудаас Ерөнхий шүүгчийн ажлын алба дутмаг байгаа тул Эрүүгийн болон Иргэний чиглэлээр тус тусдаа туслахтай болгох, Өргөдөл гомдлын хугацаа алдах нь татсан хэргээс их шалтгаалдаг тул картыг цэгцтэй болгох, байгууллагадаа теннис, биллиард, шатрын танхим бий болгох, Бичиг хэрэг, өргөдөл гомдлын ачаалал их байдаг тул ажлын ачааллыг тэнцвэржүүлж өгөх, 1 дүгээр давхрын “ОО”-н өрөөг засварлах, шинэ номоор номын фондоо баяжуулах, гадаадад сургуульд суралцахад дэмжлэг, туслалцаа удирдлагаас үзүүлэх, мэргэжлийн сургалтанд нарийн бичгийн дарга, туслахуудыг хамруулж өгөх зэрэг саналууд гарсан.

Дээрхи саналуудыг хэрэгжүүлэхэд бодит арга хэмжээ авч ажилласны үр дүнд дээрхи асуудлууд ерөнхийдөө шийдвэрлэгдэж, хөрөнгө, өрөө тасалгааны байдлаас шалтгаалан байгууллагадаа биллиард, теннис, шатрын танхим бий болгох ажил хийгдсэнгүй.

Хоёр. Санхүү, материаллаг хангалт, нийгмийн асуудлын талаар

Тамгын газар нь 2002 онд төсвийн хөрөнгийг зохих зардлаар нь аль болох үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр гаргахгүй, өөрийн орлогыг бүрдүүлэн ажиллахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Улсын Дээд шүүхийн 2002 оны батлагдсан төсөв **151,9** сая төгрөг байснаас, 10,0 сая төгрөг нь сантехникийн их засварын зардалд, **141,9** сая төгрөг нь урсгал зардлын төсөв байсан. Энэ онд батлагдсан төсвийг Санхүү, эдийн засгийн яамнаас бүрэн авснаас гадна бусад орлого болох **2,155,8** мянган төгрөгийг төсөвт тусган төсвийн зардлыг зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь тайлагнаж ирлээ.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд **5.325,0** мянган төгрөг төлөвлөснөөс **5,685,2** мянган төгрөг зарцуулагдсан бөгөөд **360,2** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Гэрэл цахилгааны зардалд **2,585,1** мянган төгрөг төлөвлөснөөс **2,785,5** мянган төгрөг зарцуулагдаж, **200,4** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Түлш, халаалтын зардалд **13,242,2** мянган төгрөг төлөвлөснөөс **11,663,8** мянган төгрөг зарцуулагдаж, **1,578,9** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Тээвэр, шатахууны зардалд **6,769,8** мянган төгрөг төлөвлөснөөс **6,499,2** мянган төгрөг зарцуулж, **270,6** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Шуудан, холбооны зардалд **9,146,4** төгрөг төлөвлөснөөс **13,464,2** мянган төгрөг зарцуулагдаж, **4,317,8** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Цэвэр, бохир усны зардалд **984,0** мянган төгрөг төлөвлөснөөс **716,5** мянган төгрөг зарцуулагдаж, **267,5** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Дотоод албан томилолтын зардалд **1,200,0** мянган төгрөг төлөвлөснөөс **1,678,8** мянган төгрөг зарцуулагдаж, **478,8** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Гадаад албан томилолтын зардалд **2,222,0** мянган төгрөг төлөвлөснөөс **2,222,0** мянган төгрөг зарцуулагджээ;
- Ном, хэвлэл авах зардалд **720,0** мянган төгрөг төлөвлөснөөс **377,1** мянган төгрөг зарцуулагдаж, **342,9** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Нормын хувцас авах зардалд **150,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **150,0** мянган төгрөг зарцуулагдсан;
- Урсгал засварын зардалд **500,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **2,569,9** мянган төгрөг зарцуулагдаж, **1,769,8** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Гадаад зочны зардалд **6,000,0** мянган төгрөг төлөвлөснөөс **2,121,7** мянган төгрөг зарцуулагдаж **3,878,3** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Байрны түрээсийн зардалд **303,2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **303,2** мянган төгрөг зарцуулагдсан;
- Буцалтгүй тусламж, тэтгэлэг урамшууллын зардалд **4,319,2** мянган төгрөг төлөвлөснөөс **6,520,9** мянган төгрөг зарцуулагдаж **2,201,7** мянган төгрөгөөр хэтэрсэн байна;
- Төлбөр хураамж болон бусад зардалд **1,173,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **3,878,4** мянган төгрөг зарцуулагдаж, **2,705,4** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Бараа үйлчилгээний бусад зардалд **50,321,2** мянган төгрөг төлөвлөснөөс **54,115,4** мянган төгрөг зарцуулагдаж, **3,794,2** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Нийгмийн даатгалын шимтгэлд **18,535,9** мянган төгрөг төлөвлөснөөс **18,352,4** мянган төгрөг зарцуулагдаж, **116,5** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардалд **69,075,1** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **65,253,7** мянган төгрөг зарцуулагдаж, **3,821,4** мянган төгрөгөөр хэмнэгдсэн

байдалтай байна.

2002 онд шүүгч, ажилтнуудынхаа ая тухтай ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, зарим хүмүүсийг шагнаж урамшуулах, байгууллагын тохижилт, засвар, үйлчилгээ, бичиг хэргийн зардал болон бусад зардал зэрэг төсвийн нийт зардалд **144,0** сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Тухайлбал: Албан бичиг хүргэх шуудангийн зардалд **4,632,7** мянган төгрөг, канон, принтер, факсын хорны үнэ **2,302,0** мянган төгрөг, шүүгчийн туслахуудыг принтерээр хангахын тулд **4** ширхэг принтер шинээр авахад **1719,8** мянган төгрөг, дугтуй, маягт авахад **809,2** мянган төгрөг, бичгийн 1, 2 дугаар цаасны үнэ **471,0** мянган төгрөг, канон, утасны аппарат засварлахад **50,6** мянган төгрөг, компьютерийн сэлбэгэнд **136,7** мянган төгрөг, каноны сэлбэгэнд **287,5** мянган төгрөг, архивын зориулалтын галын хор 1 ш авахад **23,0** мянган төгрөг, өдрийн гэрэл авахад **47,5** мянган төгрөг, коридорийн толь авах, түүний хүрээ хийлгэхэд **185,9** мянган төгрөг, цэвэрлэгээний материалд **191,0** мянган төгрөг, бусад зардалд \диск, залгуур, монометр, уян холбоос жийрэг, бага хэмжээний засвар зэрэг\ **67,2** мянган төгрөг, шүүгч, ажилтнуудын телефон утасны зардалд **6874,6** мянган төгрөг, Ерөнхий шүүгчийн гар утасны төлбөрт **596,1** мянган төгрөг, Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимын Тэргүүнүүдийн утасны карт авахад **242,1** мянган төгрөг, зарим шүүгчдийн дипломат паспортны сунгалтын үнэ **20,0** мянган төгрөг, 1 дүгээр давхрын “00” өрөөг засварлахад **246,3** мянган төгрөг, автомашины сэлбэг авахад, автомашины даатгал, татвар, оношлогоонд **1555,4** мянган төгрөг, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди анх удаа Улсын Дээд шүүх, Нийслэл, зарим дүүргийн шүүхийн ажил байдалтай биечлэн танилцах үед Монголын шүүхийн шүүн таслах ажлын ачаалал, үзүүлэлтийг харуулах газрын зурагны үнэ **110,0** мянган төгрөг, Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн “Цагаан сар”-ыг тохиолдуулан Ахмад настнууддаа хүндэтгэл үзүүлж, тэдэнд бэлэг дурсгалын зүйл өгөхөд **357,0** мянган төгрөг, Эх үрсийн баярыг тохиолдуулан шүүгч, ажилтнуудынхаа Ерөнхий боловсролын дунд сургуульд суралцдаг болон цэцэрлэгийн насны хүүхдүүдэд бэлэг авч өгөхөд **350,0** мянган төгрөг, Нийслэлийн шүүхийн 75 жил, Сонгуулийн Ерөнхий хорооны 10 жилийн ойг тохиолдуулан дээрхи байгууллагуудаас санал болгосон шүүгч, ажилтнуудыг шагнахад **334,5** мянган төгрөг, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч асан, Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэлцэрэнгийн 50 насны ойг тохиолдуулан хадаг, мөнгөн аяга зэрэг дурсгалын зүйл өгөхөд **64,5** мянган төгрөг, АНУ-ын Техас муж улсын Уэслианы Их Сургуулийн захирал доктор Жой Спурлок II, ОХУ-ын Буриадын Үндсэн хуулийн шүүхийн дарга К.А.Будаев, ХБНГУ-ын Бавари муж улсын Хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн сайд, доктор М.Вайс, Нюрнбург дахь Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгч Ё.Кают, АНУ-ын муж улсуудын шүүхийн үндэсний төвийн Олон Улсын хөтөлбөрийн хэлстийн менежер, хатагтай Кейн Кларк, Олон Улсын Хүний эрхийн хуулийн группийн Азийг хариуцсан ажилтан хатагтай Маргерет Карфенгер, хатагтай Женифер Расмюшен, Дэлхийн банкны төслийн удирдагч, ноён А.Трофт, Азийн хөгжлийн банкны засаглал хариуцсан зөвлөх, ноён М.Раммиш нарын зэрэг гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, хүндэтгэлийн зоог барих, бэлэг дурсгалын зүйл өгөхөд **1,347,8** мянган төгрөг, шүүх хуралдааны танхимын шүүгчдийн сандалны /20 ш/ жижиг хивсэнцэр авахад **80,0** мянган төгрөг, шүүгч ажилтан нийт 16 хүнд олгосон буцалтгүй тусламжинд **1,833,4** мянган төгрөг, Монгол Улсын “Гавъяат хуульч” агсан М.Могноон, Ц.Рашзэвэг нарын хөрөг зуруулахад **90,0** мянган төгрөг, Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдааны танхимыг засварлахад **1,756,0** мянган төгрөг, Тендерийн материал бэлтгэхэд **45,0** мянган төгрөг, шүүгч, ажилтнуудыг Интернетээр хангахын тулд Миком ХХК-тай гэрээ хийж **129,3** мянган төгрөгийг интернэтийн төлбөрт, шүүгчийн тохь тухтай нөхцлийг бүрдүүлэх үүднээс С.Нямжав, М.Дамирансүрэн, Д.Батсайхан, А.Доржготов, Б.Доржготов нарын өрөөг туузан хөшигтэй болгоход **250,6** мянган төгрөг, Нийслэлийн гал түймэртэй тэмцэх газрын албаны албан шаардлагын дагуу **380,0** мянган төгрөгийг галын аюулгүй байдлыг хангах үүднээс тус тус төсвөөс зарцуулж, санхүүгийн тайлан балансад тусгалаа.

Түүнчлэн **түрээсийн орлого** болох **4,830,5** мянган төгрөгийг төсвийн зардал мөнгө хүрэлцдэггүйгээс дараах арга хэмжээнд зарцуулаад байна.

Тухайлбал: Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн “Цагаан сар”-ыг тохиолдуулан Ахмад настанууддаа хүндэтгэл үзүүлж тэднийг хооллуулахад **215,0** мянган төгрөг, Олон Улсын Эмэгтэйчүүдийн баяр “Мартын 8”-ныг тохиолдуулан эмэгтэйчүүддээ өгсөн бэлэг дурсгалын зүйлд **273,8** мянган төгрөг, Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүлээн авахад **30,0** мянган төгрөг, УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэлцэрэнгийн төрсөн охин нь нас нөгцөхөд буцалтгүй тусламж олгоход **50,0** мянган төгрөг, өндөр настан Оросоод **30,0** мянган төгрөг, Ерөнхий шүүгчийн шүүн таслах, ахлах зааварлагч Ц.Цогтод буцалтгүй тусламж **100,0** мянган төгрөг, шинэ номны үнэ **79,8** мянган төгрөг, Эрүүгийн шүүн таслах ажил эрхэлсэн ахлах шинжээч, шүүгчийн туслахаар ажиллаж байсан А.Ичинхорлоог Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Нийслэлийн шүүхийн шүүгчээр томилогдоход нь дурсгалын зүйлс өгөхөд **25,0** мянган төгрөг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт” медаль, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор “Шүүхийн тэргүүний ажилтан” цол тэмдэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар “Хууль зүйн тэргүүний ажилтан” цол тэмдэг, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамжаар “Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Өргөмжлөл”-өөр шагнагдсан шүүгч, ажилтнуудыг

хүлээн авч, баяр хүргэх ажиллагаанд **158,3** мянган төгрөг, яруу найрагч З.Түмэнжаргалын “Монголын тал нутаг” CD-ний баяр – бүх оддын тоглолтыг Залуучуудын зөвлөлийн гишүүн Улсын Дээд шүүхэд ажиллаж байгаа 25 залуучууддаа үзүүлэхэд **150,0** мянган төгрөг, хяналтын шатны 16 удаагийн 41 өдрийн шүүх хуралдаанд оролцогчдод цайны үнэнд **120,0** мянган төгрөг, видео касет, компьютерийн диск, плёнкны үнэ **24,0** мянган төгрөг, төрийн ордны утасны жагсаалтны үнэ **5,0** мянган төгрөг, 1 дүгээр давхрын “00”-ын өрөөг засварлахад **640,0** мянган төгрөг, автомашины сэлбэгэнд **74,5** мянган төгрөг, цэвэрлэгээний материалд **21,2** мянган төгрөг, бусад зардалд \төрийн далбаа, цоож, галын самбар, гар хатаагч, уртасгагч, замаск гэх мэт авахад\ **493,0** мянган төгрөг, эмчийн цалинд **60,0** мянган төгрөг, гадаадын зочдын зоогт **199,5** мянган төгрөг, гадаадын зочдод ус, чихэр авахад 127,9 мянган төгрөг, бэлэг дурсгал авахад **135,9** мянган төгрөг, байгууллага ажилчдаа амралтанд авч явахад **485,0** мянган төгрөг, жил бүр хуулийн байгууллагуудын дунд зохиогддог спортын тэмцээнд **170,3** мянган төгрөг, эрүү, иргэний хэргийн хуралдааны танхим засахад **73,0** мянган төгрөг, Шүүхийн тухай хуулийн ажлын хэсгийн оройн зоогт **77,2** мянган төгрөг, шинэ жилийн арга хэмжээнд **895,8** мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

2002 онд тамгын газраас байгууллагаа тохижуулах, шүүгч, ажилтнуудын ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллалаа.

Улсын дээд шүүхийн барилгын сантехникийн их засварын ажлыг зайлшгүй хийх шаардлагатай байсан тул уг ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн материалыг бэлтгэн, урилгыг “Өдрийн сонин”-д зарласны дагуу 8 оролцогч тендерийн материалаа ирүүлснийг “Тендерийн хорооны гишүүд, үнэлгээний ажлын хэсэг”, “Тендерийн хороо”-ны дүгнэлтийг үндэслэн “Би Софт” ХХК-ийн гүйцэтгэгчээр шалгаруулан, сантехникийн их засварын ажлыг 2002 оны 5 дугаар сарын 21-нээс 6 дугаар сарын 24-ний хооронд хийлгэж дуусган, Дулааны шугам сүлжээний байцаагчийг байлцуулан уг ажлын гүйцэтгэлийг техникийн комиссын бүрэлдэхүүнтэйгээр хүлээн авч, хэвийн үйл ажиллагаанд оруулснаар энэ өвөл шүүгч, ажилтнууд бид тав тухтай, дулаан нөхцөлд ажлаа явуулж байна.

Сантехникийн их засварын ажилд идэвх зүтгэл гарган ажилласан Хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, жолооч Г.Батчулуун, слесарь Б.Ширэндэв, үйлчлэгч Б.Оюунцэцэг, Б.Уртнасан нарт хамт олны зүгээс талархал илэрхийлж байна.

Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх алба, Дулааны цахилгаан шугам сүлжээний газар, Төрийн холбооны газар, “Нийслэлийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн Чингэлтэй дүүрэг дэх салбарын байцаагчийн албан шаардлагын дагуу зам гарцыг чөлөөтэй болгох зорилгоор 1 дүгээр давхрын зүүн жигүүрийн шатанд хаалга бий болгон, узелийн өрөөний дулааны монтажийг буцахаас буцахад болгон өөрчлүүлж, шинээр 1 ш хаалт тавьж, нурсан дулаан түгээх худгийг цэвэршүүлэн, тагыг шинээр бетондон цутган хийлгэж, шинээр тавигдах утасны тоог 54-өөр тогтоон гаргаж, давхаруудын бүдүүвч зургийн хамт Төрийн холбооны газарт хүргүүлж, цахилгааны системд трансформаторуудын шугмын хэмжилт хийлгэн, тоолуурыг давхар лацтай болголоо.

Шинээр батлагдан мөрдөгдөж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүхийн тухай хуулиар Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаан 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянаж хэлэлцэх болсонтой холбогдуулан Эрүүгийн болон Иргэний хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны танхимыг шинээр засварлан дуусаж, үйл ажиллагаанд нь орууллаа.

Түүнчлэн ХБНГУ-ын “Ханнс-Зайдел”-ийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Нийт шүүгчдийн шүүх хуралдааны танхимд ауди болон санал хураалтын систем, бусад тоног төхөөрөмжийг “Ди-Си-Электроник” ХХК-аар суурьлуулан, шүүгчдийн сандалыг савхин бүрээстэй сандлаар солилоо.

“Шүүхийн хуралдааны танхим” гэсэн Шүүхийн бэлэг тэмдэг “Дэнс” бүхий хаяг, бүх давхруудын вестибюльд хүрээ бүхий толь, хурлын танхим, өрөөнүүдэд тюль, хөшиг 25 м, шүүх хуралдааны танхимын 2 хаалга болон зарим өрөөний хаалганы цоожийг шинээр сольж суулган, архивын өрөөнд ОПУ-4 маркийн зориулалтын галын хор байрлуулж, 1, 4 дүгээр давхруудын коридорын хаалганы шилийг арзгар гадаргуутай боржин шилээр сольж “Мон-Дуулга” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 1 дүгээр давхрын “00” өрөөг иж бүрэн засварлуулж, бүх давхруудын “00” өрөөнд цаас тогтоогч, 3 дугаар давхрын “00” өрөөнд гар хатаагч суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор принтерийн хорыг цэнэглэгчээр дахин цэнэглэн ашиглаж байна.

Энэ оны 2 дугаар улиралд улс орон даяар зохиогдсон автотехникийн үзлэгт байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа 5 автомашиныг оруулж, оношлогоо тогтоолгон “2002” он гэсэн зөвшөөрлийг авлаа.

Манай шүүхийн хамт олны дотроос гачигдал тохиолдсон зарим шүүгч, ажилтнуудад зохих хэмжээний буцалтгүй мөнгөн тусламж үзүүлж ирлээ.

Тухайлбал: шүүгч С.Нямжавын төрсөн ээж Н.Даваа, Иргэний хэргийн танхимын шүүх хуралдааны зохион байгуулалт хариуцсан зааварлагч Ч.Жаргалсайханы төрсөн ах Ч.Төмөр, Хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэнгийн төрсөн ээж Н.Цэрэнбумаа, Хууль тогтоомжийн системчлэлийн ажил хариуцсан зааварлагч Ё.Цэрэндэжидийн төрсөн эгч Ё.Содномдэжид, Төрийн хууль цаазны жинхэнэ зөвлөх, прокурорын хүндэт ажилтан, дэслэгч генерал Ж.Балжинням, Улсын Дээд шүүхийн Ахмадын зөвлөлийн гишүүн, өндөр настан Б.Зэнэмъядар, Н.Лундаа, Э.Гомбожав, Б.Пунцагдулам, Бичиг хүргэгч Д.Долгорсүрэнгийн төрсөн хүүхэд Д.Болор-Эрдэнэ, үйлчлэгч Ц.Цэцэгсүрэнгийн хадам аав Д.Санжжав, хадам ээж Г.Должин нарыг нас нөгцөхөд, тэдний ар гэрийнхэнд нийт **400,0** мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар тус тус олголоо.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудаас өвчлөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед Тамгын газар, хамт олны зүгээс халамж, тусламж үзүүлэх зорилготой халамжийн санд **238,6** мянган төгрөг бүрдсэнээс Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Н.Төрбат, Иргэний хэргийн танхимын тэргүүн Р.Жамъянчойжил, шүүгч Б.Доржготов, Д.Тунгалаг, шүүгчээр ажиллаж байсан Б.Дангаасүрэн, Шүүхийн судалгааны төвийн захиралаар ажиллаж байсан Ц.Бүжинлхам, Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референт Б.Баясгалан, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах Р.Ишцог, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Н.Дуламсүрэн, С.Одгариг, Иргэний хэргийн танхимын шүүх хуралдааны зохион байгуулалт хариуцсан зааварлагч Ч.Жаргалсайхан, Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, Санхүү, хангамж хариуцсан ахлах нягтлан бодогч Б.Хишигсүрэн, операторчаар ажиллаж байсан П.Элбэгбаяр, бичээч А.Пүрэвдулам, жолооч Б.Пүрэв, үйлчлэгч Ц.Цэцэгсүрэн, Д.Оюунцэцэг нарыг тус бүр 1-2 удаа **5000** төгрөгөөр, нийт **125,0** мянган төгрөгийг халамжийн сангаас гарган эргэж, одоо **113,6** мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2002 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 23 дугаар тушаалаар байгуулагдсан тооллогын комисс нь ажлын 15 хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, хуралдааны танхим, коридор, бестбюльд байгаа эд зүйлсийг хариуцсан үйлчлэгчдийн карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг үлдэгдлээр нь менежер – нягтлан бодогчын бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр **102,280,752** төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, 4,209,635 төгрөгийн үнэ бүхий бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, **3,554,192** төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, **80,301,320** төгрөгийн үнэ бүхий бүхий **5** автомашин тоологдлоо.

Тооллогын комиссын саналыг үндэслэн эвдэрч хэмхрэн ашиглагдахгүй болсон зарим эд хөрөнгийг акталж, данснаас хасах шаардлагатай тул Төрийн өмчийн хорооноос зохих зөвшөөрөл авч шийдвэрлүүлэхээр бэлтгээд байна.

Гурав. Сургалтын талаар

2002 онд Тамгын газрын ажилтнууд төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион явуулсан сургалт, семинаруудад идэвхтэй оролцлоо.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хүний эрхийн Үндэсний комисс, “Шүүх эрх мэдлийн шинэтгэл”-ийн хөтөлбөр, “Ханнс-Зайдел”-ийн сан, “Хуульч эмэгтэйчүүдийн холбоо”-ноос зохион явуулсан “Төрийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох нь” сургалтад Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар, “Хүний эрхийн салбар дахь олон улсын гэрээ,

конвенцийн хэрэгжилт” сургалтад шүүгчийн туслах Д.Батбаатар, Г.Даваадорж, Ц.Оч, Ж.Эрдэнэчимэг, “Ажлын ачааллыг судлах нь” сургалтад Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа эрхэлсэн шинжээч Ц.Нарангэрэл, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар, “Хууль зүйн дээд боловсрол олгох, хуульчдыг сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгох асуудал” онол-практикийн бага хуралд дотоод ажил зохион байгуулалт, хяналтын ажил эрхэлсэн референт Б.Баясгалан, “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн үзэл баримтлал” онол-практикийн бага хуралд Шүүхийн судалгааны төвийн захирал П.Цэцгээ нар санал бодлоо илэрхийлэх, хэлэлцүүлэгт асуулт тавих, үг хэлэх зэргээр идэвхитэй оролцлоо.

“Хуульчдын давтан сургалтын төв”-өөс зохион явуулдаг ээлжит сургалтад тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэгийг хамрууллаа.

“Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн төслийн хүрээнд “Сантис боловсролын төв”-ийн Англи хэлний 6 сарын дамжаанд кодификаторч Ц.Нарангэрэл, Судалгааны төвийн захирал П.Цэцгээ нар анги дэвшин үргэлжлүүлэн суралцлаа.

АНУ-ын Адвокат интернейшнл байгууллагын дэмжлэгтэйгээр зохион явуулж буй Англи хэлний сургалтанд Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Д.Батбаатар, Н.Дуламсүрэн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах М.Алдар, Г.Даваадорж, Хэвлэл мэдээллийн төлөөлөгч Р.Ганпүрэв, Иргэний хэргийн танхимын шүүх хуралдааны зохион байгуулалт хариуцсан зааварлагч Б.Оюунбилэг, Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт, иргэний хэргийн танхимын нарийн бичгийн дарга Ц.Оч, номын санч Б.Туяа, Архив, тамгын газрын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Оюунханд нар өөрсдөө санаачлага гарган 7 хоногт 3 удаа хичээллэж, гадаад хэл бие даан суралцахдаа идэвх чармайлт гарган суралцаж байна.

“Ханнс-Зайдел”-ийн сангийн Эрх зүйн боловсрол академи, FM 104,5 радиотой хамтран зохион явуулж байгаа “Хуульчийн цаг” нэвтрүүлэгт Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах М.Алдар, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Н.Дуламсүрэн нар 20 гаруй удаа оролцон, шинээр мөрдөгдөж байгаа Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Хөдөлмөрийн тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай, Нийгмийн даатгалын багц хуулиудын зарим зүйл, заалтын талаархи хөдөлмөрчдийн асуултанд хариулт өгч, ярилцлага хийхэд оролцжээ.

2002 онд бусдаасаа илүү идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажилласан хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах Б.Бат-Эрдэнэ, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Д.Батбаатар, Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэг, хууль тогтоомж системчлэлийн ажил хариуцсан зааварлагч Ё.Цэрэндэжид, санхүү хангамж хариуцсан ахлах зааварлагч-нягтлан бодогч Б.Хишигсүрэн, бичээч Д.Оюунчимэг, Д.Пүрэвдулам, жолооч Г.Батчулуун, Б.Пүрэв, слесарь Б.Ширэндэв, үйлчлэгч Л.Мөнхравжих, Д.Оюунцэцэг, Д.Оюунчимэг, Д.Уртнасан, Ц.Цэцэгсүрэн, нарт хамт олныхоо өмнөөс талархал илэрхийлж, цаашдын ажилд нь амжилт хүсье.

2002 онд Улсын Дээд шүүхийн тамгын газар дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд нийт шүүгч, ажилтнуудын уйгагүй хөдөлмөр, идэвх санаачлага, хамтын ажиллагаа ихээхэн нөлөөлж, дэвшүүлсэн зорилтоо бүрэн биелүүлэх боломж бүрдсэн гэж дүгнэж байна.

2003 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн Төсвийн удирдлага санхүүжилтын тухай хууль мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан гарсан Засгийн газрын 119 дүгээр тогтоолын дагуу бүтцийн өөрчлөлт хийгдэж байгууллагын орон тоо, цалингийн сан тодорхой хувиар хорогдуулах тул ажлын байрны тодорхойлолтод ялимгүй өөрчлөлт орж, ажлын ачаалал нэмэгдэж, ажлын байранд тавигдах шаардлага ихээр өндөрсөх болно.

Бид ажилтнуудад шаардлагатай байгаа бүх техник хэрэгслээр хангаж, та бүхнээс зөвхөн илүү үр дүнтэй, бүтээмжтэй ажиллахыг шаардах болно. Тэрхүү шаардлагыг биелүүлж чадахгүй байгаа хүмүүст өндөр цалин өгч, өдөр хоног өнгөрүүлсэн байдлаар ажиллуулахгүй байх зарчмыг хатуу баримтална. Тухайн ажлын байранд ажиллаж чадах эсэх нь та бүгдээс өөрсдөөс чинь шалтгаалах болно гэдгийг хатуу ойлгох хэрэгтэй.

Ирэх онд тамгын газрын ажилтнууд та бүхэн Дээд шүүхийн төлөвлөгөөнд болон ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан зорилго, зорилт, үүргээ чанартай биелүүлж, ололт амжилтаа

улам бататган чанаржуулж, өөрт оршин буй дутагдлыг бүрмөсөн арилгах, сахилга бат, ажлын цаг ашиглалтыг ягштал чанд баримтлан, иргэд хөдөлмөрчидтэй харьцах харьцааны соёлжилтыг өндөржүүлэн, ихийг санаж сэдэж, үр бүтээлтэй ажиллана гэдэгт итгэл төгс байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗАР**